# ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу ХЭРЭГЖИЛТ /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА, ХЭМЖЭЭ*** | | | | | | | |
| **1.1. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХАД СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ, ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, ӨРГӨЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.1-ИЙН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| ***1.1.1.МУ-ын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн салбарын бодлого чиглэлийг тодорхойлох, бодлогын үр нөлөөг үнэлэх, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг боловсруулах, хууль тогтоомжийг шинэчлэх үндэслэл, хэрэгцээ шаардлагыг судлах, бодлого хэрэгжүүлэх стратеги, хөтөлбөр, төсвийн хэрэгцээг боловсруулахад холбогдох газруудад дэмжлэг үзүүлэх;*** | | | | | | | |
| 1. | Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх санал боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2020-2024 2.5.5 НДЕХ шинэчилсэн найруулга 36.1.2/* | Улсын төсөв 449.3 тэрбум төгрөг | Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх ЗГ-ын тогтоолын төсөл | НДС-аас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээ 550.0 мянган төгрөг, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 440.0 мянган төгрөг, дундаж тэтгэвэр 686.9 мянган төгрөг | Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх Засгийн газрын тогтоолыг батлуулсан байна. | 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын 120 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхээр, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 650.0 мянган төгрөгт, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 540.0 мянган төгрөгт тус тус хүргэхээр баталсан. Ингэснээр дундаж тэтгэврийн хэмжээ 787.0 мянган төгрөгт хүрээд байна.<br>Түүнчлэн Засгийн газрын 2024 оны 122 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 50 мянган төгрөгөөр нэмэгдэж 375 мянга, асаргааны тэтгэмжийн хэмжээ 10 хувиар нэмэгдэж 302.5 мянган төгрөгт хүрсэн. | 100 |
| 2. | Нийгмийн халамжийн шинэчлэлд тусгасан зорилтот өрхийг чадавхижуулах халамжийн үйлчилгээний загвар тодорхойлох зорилгоор АХБ-ны төслийн дэмжлэгтэйгээр | АХБ-ны төсөл 521.0 сая төгрөг | Туршилтын хөтөлбөрт хамрагдсан 1277 өрхөөс амьжиргаа нь дээшилсэн өрхийн тоо | Төсөл хэрэгжиж байгаа бөгөөд төсөл хэрэгжих хугацаа 2024 оны 08 дугаар сарын 31 хүртэл сунгагдсан. | Туршилтын хөтөлбөрийг 2024 оны 7 сар хүртэл хэрэгжүүлж дуусгах, төсөлд хамрагдаж дэмжлэг авсан өрхийн 80-аас доошгүй хувийн амьжиргаа нь дээшилсэн байна. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийг Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Цар тахлын үе хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2“-ын хүрээнд 2022 оны 7 дугаар сараас 2025 оны 8 дугаар сарыг дуустал буюу 36 сарын хугацаатайгаар хэрэгжүүлж байна. Уг туршилтын хөтөлбөрийг нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | "Төгсөлтийн аргачлалыг хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөр"-ийг нийслэлийн 3 дүүрэгт туршин хэрэгжүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.5, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.4, МУЗГҮАХ 2020-2024 2.5.9, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 3.5./* | | | | | хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнсний эрхийн бичгийн хөтөлбөрт хамрагддаг 1,259 зорилтот өрхийн нийгмийн болон санхүүгийн чадавх, оролцоог сайжруулах цогц арга хэмжээнд хамруулан 80-аас багагүй хувийг нь бие даан тогтмол орлоготой болж, тогтвортой амьжиргаанд хүргэхийг зорьж байна.<br>Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийн хүрээнд 11 төрлийн тоног төхөөрөмжийг олгож 1256 өрхөд олгосон, өрхүүдийн хөрөнгө ашиглалтын байдалд үнэлгээ хийсэн,<br>ГБХНХЯ-ны ТНБД-ын ахалсан ажлын хэсгийг шинэчлэн батлуулж, 3 удаагийн хурлыг зохион байгуулсан. Төсөлд хамрагдаж байгаа өрхүүдийг дэмжих, ажлын байраар хангах, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг зах зээлтэй холбох зэрэг ажлуудыг үе шаттай зохион байгуулж байна.<br>Зорилтот өрхийг чадавхижуулах халамжийн үйлчилгээний загварыг тодорхойлж, 2024 оны 4 дүгээр улирлаар хөтөлбөрт хамрагдсан нийт өрхийн амжиргааны түвшин, хөрөнгө ашиглалтын ахиц 78.1 хувьтай байна. | |
| 3. | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд са нал хүргүүлнэ. | үйл ажиллагаан ы зардал | Хүргүүлсэн санал, тооцоо, судалгааны тоо | 2024 оны хүргүүлсэн санал | ЭЗХЯ-нд санал хүргүүлж, саналыг тусгуулсан байна. | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг газар, хэлтсүүдээс авч нэгтгэн 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 01/671 тоот бичгээр, нэмэлт саналыг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01/694 тоот албан бичгээр тус тус ЭЗХЯ-д хүргүүлсэн. | 100 |
| 4. | Ядуурлыг бууруулах талаар баримтлах стратегийн төслийг боловсруулж хэлэлцүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.4, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.3, МУЗГҮАХ 2020-2024 2.1.7/* | үйл ажиллагаан ы зардал | Стратегийн төслийн тоо-1<br>Хэлэлцүүлэг-2 | Стратегийн төслийг боловсруулаагүй байгаа. | Төслийг боловсруулж, 2-оос доошгүй удаа хэлэлцүүлсэн байна. | Ядуурлыг бууруулах асуудлаарх салбар дундын зохицуулалтыг сайжруулах зорилгоор Ядуурлыг бууруулах үндэсний зөвлөл байгуулахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж байна.<br>АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжүүлж байгаа "Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2"-ын хүрээнд Ядуурлыг бууруулах үндэсний стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээг авч ажиллуулах асуудлыг төслийн 2024 оны төлөвлөгөөнд тусгасан. Энэ зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан ажиллаж байна. | 30 |
| 5. | Ядуурлыг бууруулахад салбар, байгууллага, олон нийтийн оролцоог | үйл ажиллагаан ы зардал | Үндэсний хэлэлцүүлэг-1 | - | Үндэсний хэмжээний хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. | Ядуурлыг бууруулах, өрхийн амьжиргааг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 20 гаруй байгууллагыг оролцуулсан уулзалт- | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлэх асуудлаар үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулна. | | | | | хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уулзалтад оролцогч байгууллагуудыг оролцуулсан хамтын ажиллагааны сүлжээ байгуулахаар тогтсон. Сүлжээний зохицуулагчийн үүргийг Дэлхийн зөн олон улсын байгууллага гүйцэтгэх бөгөөд хагас жил тутам уулзалт зохион байгуулж, ажлын мэдээллээ солилцох, үйл ажиллагаагаа уялдуулахаар болсон. Сүүлийн хагас жилд Ядуурлыг бууруулах үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулах, ядуурлыг бууруулах үндэсний стратегийг боловсруулах зэрэг ажилд хамтран ажиллах болно. Ядуурлыг бууруулах үндэсний стратегийн төслийг боловсруулж, энэ форумаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Форумыг зохион байгуулах төсвийн саналыг боловсруулж, АХБ-ны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-т хүргүүлсэн. | |
| 6. | “Нийгмийн халамжийн тогтолцоо” олон улсын хэлэлцүүлэг зохион байгуулна. | АХБ-ны төсөл 20.0 сая төгрөг | Нийгмийн халамжийн чиглэлээр бусад орны сайн туршлага судлах хэлэлцүүлэг -1 | Бэлтгэл ажил хийгдэж байгаа | Хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хангаж ажилласан байна. | Нийгмийн хамгааллын олон улсын хурлыг 2024 оны 10 дугаар сарын 29,30-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан. Уг хуралд Азийн хөгжлийн банкны гишүүн орнууд болох Азербайжан, Пакистан, Филиппин, Индонез, Узбекистан зэрэг улсын төлөөллүүд оролцож, харилцан хоорондоо туршлага солилцож ажилласан. Мөн Монгол Улсад үр дүнтэй хэрэгжиж буй "Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ"-ний хэрэгжилт, "Төгсөлтийн аргачлалын хөтөлбөр"-т хамрагдсан өрхүүдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнтэй танилцаж, БЗД-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст ажилласан. | 100 |
| 7. | Үндэсний индекс/кодоор үүсгэсэн 100-аас доошгүй ажил, мэргэжлийг сонгон авч тодорхойлолт, чиг үүрэг зэрэг холбогдох мэдээллийг боловсруулж, ҮАМАТ-08-ын цахим системд цэс үүсгэн оруулах ажлыг эхлүүлнэ. | үйл ажиллагаан ы зардал | 100-аас доошгүй ажил, мэргэжлийн тодорхойлолт, мэдээлэл | Зарим ажил, мэргэжлийн тодорхойлолтууд боловсруулагдаагүй байна. | 100-аас доошгүй ажил, мэргэжлийн тодорхойлолтыг боловсруулж, ҮАМАТ-08-ын цахим системд оруулсан байна. | Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн хүрээнд зөвлөх үйлчилгээ авч ҮАМАТ-08-д ангилагдсан 155 ажил мэргэжлийн тодорхойлолт, чиг үүрэг, ур чадвар, холбогдох ажил мэргэжлийн жишээ бүхий мэдээллийг боловсруулах, ҮАМАТ-08-ын цахим системд шаардлагатай цэсийг үүсгэн, зарим засвар өөрчлөлт оруулах ажлыг хийж байна. Үндэсний индекс/код бүхий 155 ажил мэргэжлийн лавлах төслийн байдлаар боловсруулагдаад байна. Сайжруулалт, өөрчлөлт хийсний үндсэн дээр ГБХНХ-ын сайдын тушаалаар батлуулж, ҮАМАТ-08-ын цахим системд оруулахаар төлөвлөж байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***1.2. МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖИЛ, ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, НИЙГМИЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН САЛБАР ДУНДЫН ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ЦОГЦ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ГЭР БҮЛ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.3-ЫН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| ***1.2.1.Хүн амын тогтвортой өсөлт, гэр бүл, хүний хөгжлийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн шинжилгээг хийх, бодлогын удирдамжаар хангах;*** | | | | | | | |
| 8. | Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хуулийг /батлагдсаны дараа/ дагалдан гарах журмыг боловсруулна. | үйл ажиллагаан ы зардал | Журам -11 | Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэхээр болсон. | Журмуудын төслийг боловсруулсан байна. | Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хуулийн төслийг ХЗДХЯ-тай хамтран боловсруулж, Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр УИХ-д өргөн барьсан. УИХ-ын Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, УИХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгэн ажилласан боловч УИХ-ын 2024 оны ээлжилт сонгуультай холбогдуулан хэлэлцэгдэж амжаагүй болно. | - |
| ***1.2.2. Хүн амын насны бүтэц, насжилт, ахмад настан, хүний хөгжлийн асуудлаар бодлого, удирдамжаар хангах;*** | | | | | | | |
| 9. | Ахмад настанд урт хугацаанд үзүүлэх тусламж үйлчилгээний цогц загварыг тодорхойлж, туршина.<br><br>*/Алсын хараа 2050-ын 3.1.13, МУЗГҮАХ 2020-2024 2.5.8/* | АХБ KSTA 9928) төсөл | -Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээний цогц загвар;<br>-Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт; | -Цогц загварыг турших арга хэмжээний төлөвлөгөөг ХНХС, ЭМС-ийн хамтарсан тушаалаар батлагдсан. | -Тусламж, үйлчилгээ үзүүлэх цогц загвар тодорхойлж, сонгосон байршилд туршсан байна. Төлөвлөгөөний биелэлт 80 хувь хэрэгжсэн байна.<br>-Ахмад настны урт хугацааны тусламж үйлчилгээг 2022-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 100 хувь хэрэгжсэн байна. | Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэ загварыг туршин нэвтрүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам хамтран 3 зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааны чиглэлтэй "Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2022 оны 6 дугаар сарын 27-ний өдрийн А/127, А/333 тоот хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна.<br>Тусламж, үйлчилгээ үзүүлэх цогц загварын хүрээнд ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний төрлүүдийг тодорхойлох зорилгоор Кейс менежментийн онол практикт тулгуурлан Монгол Улсад тохирсон "Идэвхтэй насжилтыг дэмжих төв"-ийн үйл ажиллагааны гарын авлагын төслийг дараах чиглэлээр боловсруулсан. Үүнд:<br>•Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн ерөнхий чиглэл,<br>•Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн Удирдлага зохион байгуулалт,<br>•Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ,<br>•Кейс менежментийн тогтолцоо,<br>•Кейс менежментийн нийтлэг зааврууд зэрэг юм. | 100 |
| ***1.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;*** | | | | | | | |
| 10. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн | үйл ажиллагаан ы зардал | -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай | -Үзэл баримтлалыг | -Хуулийн төсөл болон дагалдан гарах | Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөл, хуулийн тандан судалгаа, үр нөлөөний судалгаа, зардлын тооцоо болон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | найруулга, дагалдан гарах 20-иос дээшгүй хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.<br><br>*/Алсын хараа 2050-ын 2.3.3/* | | /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл-1;<br>-Дагалдан гарах хуулийн төсөл-20;<br>-Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-1 | шинэчлэн боловсруулсан. | хуулийн төслүүдийг боловсруулсан байна.<br><br>-Хуулийн зардлын тооцоо болон үр нөлөөний судалгааг хийсэн байна | хуулийг дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан.<br>Хуулийн төслийг төр, ТББ-ын төлөөлөлд 12 удаа хэлэлцүүлсэн бөгөөд сүүлийн хэлэлцүүлгийг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан.<br>Хуулийн төсөлд нийт 450 гаруй санал ирсэнээс хуулийн хүрээнд саналыг тусган ажилласан.<br>Хуулийн төслийн үзэл баримтлалыг 2023 оны 12 дугаар сард ХЗДХ-ийн сайдтай хамтран баталсан. Хуулийн төслийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 05 дугаар сарын 28-ны өдөр УИХ-д өргөн барьсан.<br>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн “32.4. Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно” гэж заасан тул хуулийн төслийг дахин боловсруулж байна.<br>Энэ хүрээнд ТББ-ын төлөөллүүдэд 5 удаа хэлэлцүүлж, хуулийн төсөлд тусгагдаагүй зарим асуудлыг нэмж тусгах хэрэгцээ, шаардлага гарсан тул хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон зардлын тооцоо, хуулийн төсөл, дагалдан гарах хуулийн төслүүдийг шинэчлэн боловсруулаад байна. | |
| 11. | Саадгүй байдал хүртээмжийн тухай анхдагч хуулийн төсөл, дагалдан гарах 20-иос дээшгүй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.<br><br>*/Алсын хараа 2050-ын 2.3.3/, МУЗГҮАХ 2020-2024, 2.5.8/* | үйл ажиллагаан ы зардал | -Үзэл баримтлал 1;<br>-Хуулийн төсөл 1;<br>-Тандан судалгаа;<br>-Зардлын тооцоо 1;<br>-Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 1; | -Үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан. | -Хуулийн төсөл болон дагалдан гарах хуулийн төслүүдийг боловсруулсан байна.<br><br>-Хуулийн зардлын тооцоо болон үр нөлөөний судалгааг хийсэн байна | “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 9 удаа хэлэлцүүлж, ирсэн саналыг тусгасан.<br>Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн үзэл баримтлалыг 2024 оны 05 дугаар сард ХЗДХ-ийн сайдтай хамтран батлуулсан.<br>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн “32.4. Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно” гэж заасан тул хуулийн төслийг дахин боловсруулж байна.<br>Хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандан судалгааг эцэслэн боловсруулсан. Мөн хуулийг дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.<br>Хуулийн төсөл 6 бүлэг 23 заалттай бөгөөд Барилга байгууламжийн хүртээмж, зам, замын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууламж, нийтийн тээврийн хүртээмж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн хүртээмж, үйлчилгээний хүртээмж гэсэн 4 чиглэлээр хүртээмжийн харилцааг зохицуулна. | |
| ***1.2.4. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;*** | | | | | | | |
| 12. | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу /хууль батлагдсаны дараа/ дагалдан гарах журмыг боловсруулна. | үйл ажиллагаан ы зардал | Журам-5-6 журам | Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж, УИХ-ын ажлын хэсэг байгуулагдан хуулийг батлуулахаар ажиллаж байна. | Журмуудын төслийг боловсруулсан байна. | - Хүүхэд хамгааллын тухай хуулийг Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан.<br>- Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны “Хүүхэд хамгааллын тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг даган гарах дүрэм, журам, стандарт, аргачлал батлах тухай” А/114, 115 дугаар батлагдаж, тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, дараах журам, дүрэм, стандарт батлагдсан.<br>1. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам,<br>2. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ёс зүйн дүрэм,<br>3. Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх аргачлал, заавар,<br>4. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам,<br>5. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог тогтоох тухай Засгийн газрын 143 дугаар тогтоол,<br>6. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрэм Засгийн газрын 2024 оны 142 дугаар тогтоолоор,<br>7. Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив,<br>8. Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал, нийгмийн ажилтны орон тоо,<br>9. Сэтгэл зүйн үйлчилгээний стандарт,<br>10. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний стандарт,<br>11. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандарт /шинэчилсэн/ тус тус батлагдсан.<br>2/ Хүүхэд хамгааллын тухай хуулийг /шинэчилсэн найруулга/ сурталчлах ажлыг 2024 оны 3 дугаар сараас эхлүүлж, 5 дугаар сарын 20-ныг хүртэл зохион байгуулагдаж, 6300 гаруй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрийн албан хаагч, эцэг эхийн төлөөлөл 2800 гаруй хүнд хууль танилцуулж, холбогдох дүрэм, журам, стандартын төсөлд санал авч ажилласан. | |
| ***1.3. ЭРЭЛТЭД НИЙЦСЭН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗӨВ, ОНОВЧТОЙ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ, ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЦАЛИН ХӨЛСНИЙ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ЗӨВШЛИЙН ГУРВАН ТАЛТ БОЛОН БУСАД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.4-ИЙН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| ***1.3.1.Хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн шинжилгээг хийх, бодлогын удирдамжаар хангах;*** | | | | | | | |
| 13. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоно.<br><br>*/Алсын хараа-2050 2.6.2, МУЗГҮАХ 2020-2024 2.5.4/* | НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр 60.0 сая төгрөг | Хуулийн төсөл-1 | Хуулийн шинэчилсэн найруулга боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Үзэл баримтлалын төсөл боловсруулсан. | Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн бүрдүүлбэрийг ханган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон байна. | Хуулийн төслийг боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд шаардлагатай Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаануудыг аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан.<br>Шинээр батлсан хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийн эхний хувилбарыг техникийн ажлын хэсгээс боловсруулсан.<br>**Үзэл баримтлалын төсөл-1**<br>**Хуулийн төсөл-1** | 90 |
| 14. | “Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай ” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | үйл ажиллагаан ы зардал | Хуулийн төсөл-1 | Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | “Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай ” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын намрын чуулганаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон байна. | Хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн, энэ хуралдааны 45 дугаар тэмдэглэлээр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу холбогдох яамдаас дахин санал авсны үндсэн дээр хэлэлцэхээр тогтсон.<br>Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дахин боловсруулан, хуулийн төслийн үзэл баримтлалыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд нар 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хамтран баталсан.<br>Уг хуулийн төслийг Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Улсын Их Хуралд 2024 оны 12 дугаар сарын 19-ний өргөн мэдүүлсэн.<br>**Хуулийн төсөл-1**<br>**ЗГ-ын хуралдааны тэмдэглэл-1** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг шинэчлэн батлуулна.<br><br>*/Алсын хараа-2050 2.6.3, 3.3.1, 3.3.3, 3.3.4, МУХТЖҮЧ 2021-2025 2.6.2, 3.3.1, 3.3.5/* | үйл ажиллагаан ы зардал | Тогтоол-1;<br>Тушаал-1; | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 3-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөрийг 2022-2023 онд хэрэгжүүлэхээр баталсан. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг ХЭҮЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан байна. | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г батлуулсан.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд 6 үйл ажиллагааны 34 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Түүнчлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/39 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлан хэрэгжүүлж байна.<br>**ХЭҮЗ-ийн тогтоол-1**<br>**ХНХС-ын тушаал-1** | 100 |
| 16. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байна. | ОУ-ын төсөл хөтөлбөр | Хуулийн төсөл -1 | Хэрэгжиж буй хууль-1 | Хуулийн төслийг нийгмийн түншлэгч талууд болон холбогдох Төрийн болон төрийн бус байгууллагуудаар хэлэлцүүлэн саналыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар шинэчлэн байгуулсан.<br>Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг хийлгэн хүлээн авч 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хуулийн тандан судалгааны дүнг ажлын хэсгийн гишүүд болон холбогдох албаны хүмүүст танилцуулсан.<br>Хуулийн төслийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгаанд үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалтын төслийг боловсруулан, ажлын хэсэг, яамдын төлөөлөл, судлаач, олон нийтээр хэлэлцүүлж хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлахаар бэлтгэж байна. | 70 |
| ***1.3.2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг боловсронгуй болгох, ажил олгогч, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд үр дүнг дээшлүүлэх;*** | | | | | | | |
| 17. | 2023-2025 оны Улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулж, биелэлтийг гаргаж Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлнэ. | үйл ажиллагаан ы зардал | Улсын хэлэлцээрийн хэрэгжилтийн хувь | 2021-2023 оны хэлэлцээрийн хэрэгжилтийн 86 хувь | Улсын хэлэлцээрийн хэрэгжилт 30 хувьтай байна. | Улсын хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлууд хийгдэж, ажлын хэсэг байгуулах Үндэсний хорооны тогтоол, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох Ерөнхий сайдын захирамж, 2023-2025 оны Улсын хэлэлцээрийг амжилттай байгуулсан.<br>2023-2025 оны Улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах төлөвлөгөөг ХНХ-ын сайдаар батлуулан талуудад хүргүүлсэн болно. Улсын хэлэлцээрийн төлөвлөгөөний дагуу ажлууд хийгдэж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндэсний хорооны тогтоолоор хамтарсан ажлын хэсэг байгуулж, яамд холбогдох газруудаас ирсэн биелэлтийг нэтгэн, талуудад тайланг хүргүүлэн ажилласан.<br>Хэрэгжилтийн хувьд 3 жил дараалан дүгнэх ба энэ жилийн хувьд Улсын хэлэлцээрийн биелэлт 70 гаруй хувьтай буюу 2024 оны биелэлтийн хувь 100% байна. | |
| ***1.3.3. Төрийн албан хаагчийн цалин хөлс, ангилал, зэрэглэлийг боловсронгуй болгох, нийгмийн баталгааны асуудлаар бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг боловсруулж, батлуулах, уялдааг хангах;*** | | | | | | | |
| 18. | Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлнэ. | Улсын төсөв: 560.4 тэрбум төгрөг | Засгийн газрын тогтоол-1 | “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” ЗГ-ын 2023 оны 241 дүгээр тогтоол | Төрийн албан хаагчдын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна. | Засгийн газрын 2024.03.27-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэн тогтоов. Уг арга хэмжээний үр дүнд төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээ 1.1 сая төгрөг (Суманд 1,540.0 мянган төгрөг, аймгийн төвийн сум болон алслагдсан гурван дүүрэгт 1,320,0 мянган төгрөг), төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээ 900.0 мянган төгрөг (Суманд 1,260.0 мянган төгрөг, аймгийн төвийн сум болон алслагдсан гурван дүүрэгт 1,080.0 мянган төгрөг) боллоо. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2024 оны 2 дугаар улирлын байдлаар нийт ажиллагчдын дундаж цалин хөлс 2,464.9 мянган төгрөг, төрийн албан хаагчдын дундаж цалин хөлс 2,417.3 мянган төгрөг байна. | 100 |
| 19. | Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно. | Улсын төсөв 59.4 тэрбум төгрөг | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | Шинээр хийх ажил | Орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам батлах тухай Засгийн газрын тогтоол батлуулсан байна. | Төрийн албаны тухай хуульд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр орсон өөрчлөлтөөр “Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох”-оор заасан.<br>Уг зохицуулалтын хүрээнд Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг батлуулав. | 100 |
| 20. | Төрийн захиргааны болон үйлчилгээний | Улсын төсөв | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | ЗГ-ын 2018 оны 382 дугаар | “Төрийн захиргааны болон үйлчилгээний | Засгийн газрын 2024 оны 02 дугаар 28-ны өдрийн 82 дугаар тогтоолоор орон нутгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан хаагчид олгодог орон нутгийн нэмэгдлийн хэмжээг аймгийн төвийн сум болон Багахангай, Багануур, Налайх дүүрэгт албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувь, хөдөөгийн суманд 40 хувиар олгоно.<br>Мөн нийтлэг үйлчилгээний албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгоно. | 308.0 тэрбум төгрөг | | тогтоол “Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам” | албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан ЗГ-ын тогтоолоор батлуулсан байна. | нэмэгдлийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг албан хаагчид үндсэн цалингийн 40 хувиар, харин аймгийн төв болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад үндсэн цалингийн 20 хувиар тооцож олгохоор холбогдох журмыг шинэчлэн батлуулав.<br>Журам батлагдсанаар өмнө нь орон нутгийн нэмэгдэл авдаггүй байсан шинжлэх ухаан зэрэг төрийн мэргэжлийн үйлчилгээний зарим албан хаагчид, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг шинээр авч эхэлсэнээр төрийн үйлчилгээний нийт албан хаагчид орон нутгийн нэмэгдэл авах юм. Мөн улс төрийн албан тушаал эрхэлдэг албан хаагчид уг нэмэгдлийг шинээр авч байна.<br>Мөн тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэж болно. | |
| 21. | Төрийн нийтлэг үйлчилгээний албан тушаалд хамаарч буй архивч, цаг уурч, лабораторийн ажилтан, мал эмнэлгийн байгууллагын албан хаагчид, нийгмийн хамгааллын зарим албан хаагчдыг ажлын онцлог, нөхцлөөс хамааруулан төрийн мэргэжлийн үйлчилгээний албан тушаалд шилжүүлнэ. | Улсын төсөв: 28.0 тэрбум төгрөг | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” ЗГ-ын 2023 оны 240 дүгээр тогтоол | Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн Засгийн газрын тогтоол батлуулсан байна. | Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулав.<br>Ингэснээр төрийн нийтлэг үйлчилгээний албан тушаалд хамаарч буй архивын салбарын албан хаагчид (1911), цаг уур, орчны шинжилгээний салбарын албан хаагчид (1893), Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборари (443), мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори (280) зэрэг лабораторийн албан хаагчид, нягтлан бодогч (2700), нийгмийн хамгааллын байгууллагын (84) нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, арга зүйч, багш, бүлгийн багш, нийт 7311 албан хаагчийг 2024 оны 04 дүгээр 01-ний өдрөөс ажлын онцлог, нөхцөлөөс хамааруулан төрийн мэргэжлийн үйлчилгээний албан тушаалд шилжүүллээ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 22. | Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2025 онд нэмэгдүүлэх тооцоо, судалгаа хийж санал боловсруулна. | үйл ажиллагааны зардал | Тооцоо, судалгаа-2 | Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2024 онд нэмэгдүүлэх тооцоо, судалгаа хийсэн. | Холбогдох тооцоо, судалгааг хийж, санал боловсруулан 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын нэгдсэн төсвийн төсөлд тусгуулсан байна. | Монгол Улсын 2025 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхэд шаардагдах төсвийн тооцооллыг холбогдох тайлбар, танилцуулгын хамт боловсруулсан. 2025 онд төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцийн түвшинтэй уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон бөгөөд уг арга хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхэд улсын төсөвт 424.4 тэрбум төгрөг нэмж шаардагдахаар байна. Мөн төрийн захиргааны албан хаагчдын цалинг нэг сүлжээнд нэгтгэн тогтооход 104.9 тэрбум төгрөг, зарим албан тушаалын ангилал, зэрэглэлийг оновчтой болгоход 15.6 тэрбум төгрөг тус тус шаардагдахаар байна. | 100 |
| 23. | Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулна. | үйл ажиллагааны зардал | Үзэл баримтлал-1 | шинээр хийх | Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/126 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлахаар 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01/740 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа болон хуулийн төслийн танилцуулгыг Засгийн газрын 3 удаагийн хуралдаанд танилцуулаад байна.<br>Мөн хуулийн төслийн хэлэлцүүлгийг Удирдлагын академи, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчдын төлөөллийг хамруулан 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын албан хаагчдын төлөөллийг хамруулан 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, яам, агентлагуудын удирдах, гүйцэтгэх албан хаагчид, нутгийн захиргааны байгууллагуудын удирдах, гүйцэтгэх албан хаагч, нийт 1600 албан хаагчдад 2024 оны 05 дугаар сарын 21-нээс 31-ний өдрүүдэд нийт 16 удаагийн хэлэлцүүлгийг танхимаар болон цахимаар зохион байгуулсан.<br>Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагийн 10 цагаас зохион байгуулдаг “7:4:10” | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит сургалтад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа” сэдвээр мэдээлэл өгч, хуулийн төслийг танилцуулсан.<br>Уг вебинарт 3500 гаруй төрийн албан хаагч оролцож, танилцуулга, мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авсан.<br>Хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн эрэмбэлж, хуулийн төсөлд тусгаад байна. | |
| ***1.3.4. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн норм, нормативын асуудлаар санал боловсруулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;*** | | | | | | | |
| 24. | Улсын хэмжээнд 2025 онд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэх тооцоо, судалгаа хийж, санал боловсруулна.<br><br>*/Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль 5.1, 6.1 дэх заалт/* | Улсын төсөв: 44.4 тэрбум төгрөг | Тооцоо, судалгаа-1 | ХНТГТҮХ-ны 2023 оны 12 дугаар тогтоолоор ХХДХ-г 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660.0 мянган төгрөгөөр тогтоосон. | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх тооцоо, судалгааг хийж холбогдох талуудтай зөвшилцсөн байна. | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 4 дүгээр сарын 19-ний 01 дүгээр тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох асуудлаар тооцоолол хийж, санал боловсруулах гурван талын хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажилласан.<br>Ажлын хэсэг 2024 оны 4 дүгээр сарын 22-нд хуралдаж, ажлын хэсэгт орсон талуудын төлөөлөл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тооцооллоо хийж, саналаа ГБХНХЯ-нд албан бичгээр ирүүлэхээр тогтсон. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос ХХДХ-г 2025 онд 1.0 сая төгрөгт хүргэх, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос 2026 оноос нэмэгдүүлэхээр 2024 оны эцсээр хэлэлцээ эхлүүлэх, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд хоёр жилд нэг удаа тогтоохоор заасны дагуу 2025 онд нэмэгдүүлэхгүй байх саналыг тус тус ирүүлсэн. ГБХНХЯ-наас ХХДХ-г бүтэн бус цагаар ажиллагчдад ялгамжтай тогтоох санал гаргасан боловч дэмжигдээгүй.<br>ХХДХ-г шинэчлэн тогтоохтой холбоотой талуудын саналыг ажлын хэсгийн гишүүдэд цахимаар, МҮЭХ-нд 2024 оны 5 сарын 29-ний 03/1586 тоот албан бичгээр мөн хүргүүлсэн.<br>Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хороо 2024 оны 10 дугаар сарын 07-ны хуралдаанаар 2025 онд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэх тооцоолол, судалгааг хэлэлцэн, зөвшилцсөний үндсэн дээр улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэг сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо. | |
| 25. | "Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08"-д шаардлагатай ажил, мэргэжлээр нэмэлт, өөрчлөлт оруулна. | үйл ажиллагаан ы зардал | Сайдын тушаалын төсөл-1 | ХНХ-ын сайдын 2022 оны А/143 дугаар тушаал | Салбарын яамдаас ХНХ-ын сайдын 2019 оны А/119 дугаар тушаалаар батлагдсан аргачлалд заасан холбогдох шаардлагыг хангаж ирүүлсэн ажил, мэргэжлээр ҮАМАТ-08-д нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 2 дугаар сарын 09-ны А/30 дугаар тушаалаар хууль сахиулах 5 ажил, мэргэжлээр нэмэлт өөрчлөлт оруулла. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/119 дугаар тушаалаар батлагдсан ҮАМАТ-08-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх аргачлалын дагуу Дотоод хэргийн их сургуулиас санал ирүүлсэн ажил мэргэжил бүрээр холбогдох мэдээллийг гарган, мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдтэй зөвшилцсөн. | 100 |
| 26. | Шаардлагатай ажил мэргэжлээр хөдөлмөрийн жишиг норм, нормативын төсөл боловсруулна. | үйл ажиллагаан ы зардал | Сайдын хамтарсан тушаалын төсөл-1 | - | Тодорхой ажил, мэргэжлээр хөдөлмөр зарцуулалтын хэмжээг судлан, ажлын ачааллыг тооцсон байна. | 1. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 2 дугаар сарын 06-ны А/37, А/16, А/126 дугаар тушаалаар "Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив" батлагдлаа.<br>2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 25-ны А/54 дугаар тушаалаар "Албан байгууллага /оффис/-ын үйлчлэгчийн цэвэрлэх талбайн жишиг норм"-ыг батлууллаа. Аж ахуйн нэгж, байгууллагууд энэхүү жишиг нормыг үндэслэн нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбайн хэмжээг тогтоох боломжтой бөгөөд мөн өөрийн байгууллагын онцлогт тохируулан хөдөлмөрийн норм, нормативаа гаргах боломжтой юм. | 100 |
| ***1.3.5.Нийгмийн халамжийн тогтолцоог боловсронгуй болгох, хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулах, ядуурлыг бууруулах салбар дундын бодлогын уялдааг хангах;*** | | | | | | | |
| 27. | Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.4, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.3, МУЗГҮАХ 2020-2024 2.1.7/* | үйл ажиллагаан ы зардал | -Хуулийн төсөл<br>-Үзэл баримтлал,<br>-Тандан судалгаа | 2012 оноос хойш хууль шинэчлэгдээгүй. | Хуулийн төсөл боловсруулан үзэл баримтлал боловсруулсан байна. | Хуулийн төслийг боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд шаардлагатай Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаануудыг аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн.<br><br>Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан.<br><br>Шинээр баталсан хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийн эхний хувилбарыг техникийн ажлын хэсгээс боловсруулж олон нийтээр хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 28. | Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.<br><br>*/МУХТЖҮЧ 2021-2025 3.1.5, МУЗГҮАХ 2020-2024 2.5.5, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 3.8./* | Улсын төсөв 62.0 тэрбум төгрөг | Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх ЗГ-ын тогтоолын төсөл | Тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдүүлэх ЗГ-ын тогтоолын төсөл | Тэтгэврийн хэмжээг 10 хувь нэмэгдүүлэх Засгийн газрын тогтоолыг батлуулсан байна. | Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 122 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлсэн. | 100 |
| 29. | “Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах, цахимжуулах төлөвлөгөө”-ний хүрээнд холбогдох журмуудыг шинэчлэн боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2020-2024 2.5.6, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.5/* | үйл ажиллагааны зардал | Засгийн газрын тогтоолын 3 төслийн 3 журам; | Журмын төсөл боловсруулж, яамдын саналыг саналыг авч байна. | ЗГ-ын тогтоолоор 3 журмын төсөл боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэсэн байна. | -Засгийн газрын 2024 оны “Хөнгөлөлтийн хэмжээ шинэчлэн батлах тухай” 159 дүгээр тогтоолоор Ахмад настны тухай хуулийн 8.1.2-т заасан ахмадын зориулалттай амралт, сувиллын нэг ор хоногт нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлтийн хэмжээ 20 000 төгрөг байсныг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлж, амралтын газарт хоногт 35 000 төгрөг, сувиллын газарт 40 000 төгрөг болгон тус тус нэмэгдүүлэн 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна.<br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/59 дүгээр тушаалаар “Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрэм, урамшууллын хэмжээ”-г шинэчлэн батлуулсан.<br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам, шалгуурыг шинэчлэн батлах тухай” А/94 тоот тушаалаар Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон ахмад настны үйлчилгээ үзүүлэх журам, үйлчилгээний чанарт тавигдах шаардлагыг шинэчлэн батлуулсан.<br>-Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар баталсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө. Үүнтэй холбоотойгоор нийгмийн халамжийн сангаас ахмад настанд олгох дэмжлэгүүд, хамрагдах нөхцөл, давтамжийн хугацаа, санхүүжилтийн зохицуулалтад орсон хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн “Ахмад настанд үзүүлэх дэмжлэгийн хэмжээ, олгох журам”, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам”, “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-ын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төслийг тус тус шинэчлэн “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар батлуулсан.<br>- Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/161, А/04 дүгээр хамтарсан тушаалаар “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал”-ыг баталж хүнсний эрхийн бичиг үйлчилгээнд хамрагдаж буй 26900 өрхийг судалгаанд хамруулсан. Үүнтэй холбоотойгоор тус яамны Бодлого төлөвлөлтийн газраас өгсөн чиглэлийн дагуу 2024 оны оны 03-04 дүгээр улиралд багтаан “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ыг дээрх аргачлалд нийцүүлэн шинэчлэн батлуулахаар журмын төслийг боловсруулж, аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдээс санал авч нэгтгэн ажиллаж байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хүрээнд халамжийн сангаас олгож байгаа хөнгөлөлт, тусламжийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулав.<br>Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, олгох процессыг иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй болгох, хэрэгжилтийн явцад тулгамдаж буй зарим асуудлыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн тогтоолын төслийг боловсруулав. Журамд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн саналыг тусгав. | |
| 30. | Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж батлуулна. | үйл ажиллагаан ы зардал | Хэлэлцүүлэг-4; | Холбогдох байгууллага, иргэнээс санал авсан | Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж батлуулсан байна. | Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2024 оны 06 дугаар сарын 05-нд Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. | 100 |
| 31. | Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | үйл ажиллагаан ы зардал | 4 журам /ЗГ-ын тогтоолын 4 төсөл/; | Холбогдох байгууллага, | | Ахмад настны тухай хуульд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг 2025 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхтэй холбоотойгоор | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоолоор батлах журмуудыг боловсруулж, батлуулна. | | | иргэнээс санал авсан | Засгийн газрын тогтоолоор 4 журам батлуулсан байна. | дараах Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дараах тогтоолуудыг батлуулсан. Үүнд:<br>“Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл /Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журам, Ахмадын сан байгуулан ажиллуулах журам/<br>“Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл /Насны хишиг олгох журам/<br>“Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл /Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам/<br>“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл /ЗГ-ын 2017 оны 197 дугаар тогтоолын хавсралт “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам”<br>Монгол Улсын Хөдөлмөрийн баатруудын холбооноос ирүүлсэн хүсэлтийг судлан Улсын баатар Хөдөлмөрийн баатар ахмад настнуудын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжруулах асуудлаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Ерөнхийлөгчийн Зарлигийн төсөл, танилцуулгын төсөл боловсруулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газарт 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01/1799 тоот албан бичгээр хүргүүлэв. | |
| 32. | Асаргааны хувилбарт үйлчилгээ, идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээг бий болгох зорилгоор ГБХНХ-ын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалыг боловсруулна. | үйл ажиллагаан ы зардал | 3 журам /ГБХНХ-ын сайд, Эрүүл мэндийн сайдын тушаал/; | Холбогдох байгууллага, иргэнээс санал авсан | ГБХНХ-ын сайд, Эрүүл мэндийн сайдын тушаалаар 3 журмын төсөл боловсруулсан байна. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдтай хамтран батлах Ахмад настны цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх, байгууллагыг сонгон шалгаруулах журмын төслүүдийг /3 журам/ боловсруулан яамны удирдлагуудад танилцуулж, Монголын ахмадын холбооны саналыг авч тусган Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/76,515 хамтарсан тушаалаар “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж үйлчилгээ үзүүлэх журам”, “Ахмад настны цогц тусламж үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам”, А/75,514 тоот хамтарсан тушаалаар “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус батлуулав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дээрх тушаалуудыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/1775 тоот албан бичгээр хүргүүлэв. | |
| 33. | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний журмуудыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | үйл ажиллагааны зардал | ГБХНХ-ын сайдын тушаал;<br>2 журам | Холбогдох байгууллага, иргэнээс санал авсан | ГБХНХ-ын сайдын тушаалаар 2 журам батлагдсан байна. | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх аргачлал, заавар, үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, үйлчилгээ үзүүлэх журам, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар, үнэ тарифын журмын төслийг боловсруулан ажиллаж байна.<br>Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасны дагуу аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, төрөлжсөн асрамжийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай журмын төслийг боловсруулан баталж, ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний нэгдсэн санд бүртгүүлэхээр ажиллаж байна. | 90 |
| ***1.4.1*** | ***Хуримтлалын нэгдсэн сангийн хууль тогтоомж, бодлого, стратеги хөтөлбөр, төсөл боловсруулах, хуримтлалын сангийн хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, зохион байгуулах, зохицуулах, сангийн гүйцэтгэлийг тайлагнах;*** | | | | | | |
| 34. | Хувийн нэмэлт тэтгэврийн даатгалыг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.<br><br>*/Алсын харааа-2050 3.1.4, ТТШТББ /2015-2030/ 3.2.17, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.1, МУЗГҮАХ 2020-2024 2.5.1.2/* | үйл ажиллагааны зардал | УИХ-ын НББХ-ны хэлэлцүүлэг;<br>танилцуулга;<br>уулзалтын тоо-3; | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулсан. | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг УИХ-ын НББХ-нд хэлэлцүүлэхтэй холбоотой ажлыг зохион байгуулж, саналыг тусгасан байна. | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/48 дугаар тушаалаар баталсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан тухай тайлан, хуулийн төслийг дагах 13 хуулийн төсөл, үр нөлөөг үнэлсэн судалгааны тайлан, зардлын тооцоог боловсруулж дууссан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль нь хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, хувийн нэмэлт тэтгэвэр олгох, тэтгэвэр өвлүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих, талуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харилцааг зохицуулна. Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа нь сайн дурын, шимтгэлд суурилсан, бүрэн хуримтлалын байх, үйл ажиллагаа, засаглал ил тод байх, санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байх, өвлөгддөг байх зарчмыг баримтлан ажиллахаар хуулийн төсөлд тусгасан. Ажлын хэсгийн гишүүд байгууллагуудаас тус хуулийн төсөлд санал авахаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 01/1211 дугаартай албан бичгээр санал авахаар хүргүүлээд байна. Мөн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөлд яамны газар, нэгжээс санал авч нэгтгэн, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хамтран батлахаар 2024 оны 01/1338 дугаартай албан бичгээр Сангийн болон Хууль зүй, дотоод хэргийн сайдад тус тус хүргүүлсэн болно. | |
| 35. | Хуримтлалын нэгдсэн санг бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.6, 3.1.7, ТТШТББ /2015-2030/ 3.3.5,МУХТЖҮЧ 2021-2025 3.1.1,МУЗГҮАХ 2.5.3.1/* | Олон улсын байгууллагын санхүүжилт 30.0 сая төгрөг | Хуулийн төсөл-1 | Хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна. | Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна. | Үндэсний баялгийн сангийн тухай хууль Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан. Үндэсний баялгийн сан нь “Ирээдүйн өв сан”, “Хөгжлийн сан”, “Хуримтлалын сан” гэсэн төрөлжсөн сангаас бүрдэнэ. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сангийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: гэж, 8.2.1-д “Хуримтлалын сангийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, батлагдсан төсвийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, сангийн үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх” гэж, 8.2.2-т “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэж, хөтлөх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах” эрхийг тус тус хэрэгжүүлнэ гэж заасан.<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмыг хэлэлцүүлж батлуулсан. Энэхүү журмаар иргэний хуримтлалын нэрийн дансыг үүсгэх, уул уурхайн олборлолт, ашигт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувьд ногдох ногдол ашгийг иргэдийн хуримтлалын нэрийн дансанд бүртгэх, жилд нэг удаа хүү тооцохоор зэргийг нарийвчлан тусгасан. Ингэснээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын 3 565.9 мянган иргэн Хуримтлалын нэрийн данстай болж, иргэн бүрт 135 мянган төгрөгийн ногдол ашгийг бүртгэсэн. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 2024 оны төсвийн тухай хуулийн дагуу 499.5 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд төвлөрүүлж, Засгийн газар, Монголбанк хооронд 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр (81-0524/171 тоот) “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ”-г байгуулж, тус сангийн мөнгөн хөрөнгийг орон сууцны ипотекийн зээлийн эх үүсвэрт зориулахаар арилжааны 9 банканд хуваарилсан. Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны урт хугацааны санхүүжилттэй уялдуулах, тогтолцооны шинэчлэлийг эхлүүлэх, шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг хийх талаар салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, нэгдсэн бодлого, шийдэл гаргах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 95 дугаар тогтоолын 41 дүгээр хавсралтаар “Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны бүрэлдэхүүнийг баталсан. Үндэсний хорооны дэд даргаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд ажиллаж байна. Орлогод нийцсэн, хүртээмжтэй орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх, ипотекийн зээлийн хүртээмжийг оновчтой болгох чиглэлээр зорилтот бүлгийг тодорхойлох судалгааг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Өрхийн мэдээллийн сангийн 2023 оны мэдээлэлд үндэслэн хийсэн. | |
| ***1.4.2. Нийгмийн даатгалын бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, хүн амын амьдралын баталгааг хангах;*** | | | | | | | |
| 36. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй | Улсын төсөв | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | Засгийн газрын 238, 239 дүгээр тогтоол | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан | Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу 2024 онд хэрэглэх итгэлцүүрийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | уялдуулан нэмэгдүүлнэ. | | | | нэмэгдүүлнэ. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуульд холбогдох зардлын тооцоог хийж батлуулсан байна. | “Итгэлцүүр тогтоох тухай” 10 дугаар тогтоолоор баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 120 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 540 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27.2-т “Энэ хуулийн 27.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлалыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална” гэж заасны дагуу Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар ”Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлал батлах тухай” 75 дугаар тогтоолыг батлуулсан. | |
| 37. | Монгол Улсаас гадаад улстай хийх нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн төслийг боловсруулах, хэлэлцээ зохион байгуулна. | Дэлхийн банк, АХБ 100.0 сая төгрөг | -Боловсруулсан баримт бичгийн тоо<br>-Нийгмийн хамгааллын чиглэлээр хамтран ажилласан улс орны тоо | Удирдлагын тохиролцоонд гарын үсэг зурахтай холбоотой бэлтгэл ажлыг хийж байгаа | Боловсруулсан хэлэлцээрийн төслийг холбогдох яаманд хүргүүлэх, хэлэлцээ хийсэн байна. | Энэхүү арга хэмжээний хүрээнд 4 улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажилласан бөгөөд 2 хэлэлцээрийн төсөл, 1 удирдлагын тохиролцооны төсөл, 1 маягтын төсөл болон дотоодын хууль тогтоомжийн дагуу бусад холбогдох баримт бичгийг боловсруулсан. Үүнд:<br><br>1.“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэх Монгол-Казахстаны шинжээчдийн 15-17 дахь шатны 3 удаагийн хэлэлцээг 2024 оны 02-05 дугаар сард цахим хэлбэрээр зохион байгуулсан. Хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн, Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэн дэмжиж, Ерөнхий сайдын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 89 дүгээр захирамжаар Хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад олгосноор сайд Л.Энх-Амгалан, Бүгд Найрамдах Казахстан Улсын Тэргүүн шадар сайд Скляр Роман | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Васильевич нар Улаанбаатар хотноо 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурсан. Мөн Бүгд Найрамдах Казакстан улсын хөдөлмөр, хүн ам нийгмийн хамгааллын төлөөлөл 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ажиллаж, хэлэлцээрийг хэрэгжүүлэх маягтын төслийг боловсруулсан. Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайланг боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/1342 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлээд байна.<br><br>2.“Монгол Улс болон Оросын Холбооны Улс хооронд Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэх шинжээчдийн түвшний 4 дэх шатны хэлэлцээгээр тохирсоны дагуу Монголын тал Хэлэлцээрийн төслийг холбогдох яамдаас санал авч зөвшилцсөн бөгөөд энэ талаар Оросын талд 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/1689 тоот нот бичгээр Оросын Холбооны Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Гадаад харилцааны яамаар уламжлуулсан.<br><br>3.Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хоорондын Нийгмийн хамгааллын хэлэлцээрийн төсөл боловсруулах эхний шатны хэлэлцээг Улаанбаатар хотод 2024 оны 02 дугаар сарын 27-28-ны өдөр, 2 дахь шатны хэлэлцээг Вена хотод 2024 оны 05 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд тус тус зохион байгуулж, хэлэлцээрийн төслийг боловсруулж, урьдчилсан зөвшилцөлд хүрсэн. Мөн талууд албаны шугамаар харилцан хэлэлцээрийг хэрэгжүүлэх Удирдлагын тохиролцооны төслийг боловсруулсан. Талууд 3 дахь шатны хэлэлцээг 2025 оны 3 дугаар сард Улаанбаатар хотод хийж, дээрх баримт бичгүүдийг эцэслэн тохиролцохоор төлөвлөж байна.<br><br>4.Монгол Улсын болон Австралийн Холбооны Улсын Засгийн газраас нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах асуудлыг тохиролцсоны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу Австралийн Нийгмийн үйлчилгээний яамтай хэлэлцээг эхлүүлэх талаар мэдээлэл солилцох уулзалтыг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтаар эхний шатны хэлэлцээг 2025 оны 01 дүгээр сард хийхээр төлөвлөөд байна. | |
| ***1.5. САЛБАРЫН ЦАХИМ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР УРТ, ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨР БОЛОЛВСРУУЛАХ, БАТЛУУЛАХ, АШИГЛАХ, ИХ ӨГӨГДӨЛД СУУРИЛСАН БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖӨӨР ХАНГАХ, СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.9-ИЙН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| ***1.5.1. E-MONGOLIA хөтөлбөрийн хүрээнд гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах, салбарт цахим засаглалыг бүрэн нэвтрүүлэх, мэдээллийн технологийг хөгжүүлэх, салбарын их өгөгдөл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, мэдээллийн зохистой ашиглалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;*** | | | | | | | |
| 38. | Нийгмийн даатгалын үйлчилгээг үргэлжлүүлэн үе шаттайгаар цахимжуулна.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.5, МУЗГҮАХ 2020-2024 2.5.6, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.3/* | үйл ажиллагааны зардал | Үйлчилгээний тоо-3 | Нийгмийн даатгалын 24 төрлийн үйлчилгээг цахимжуулсан. | Нийгмийн даатгалын цахимжуулсан үйлчилгээний тоо нэмэгдэж ажил олгогч, даатгуулагч иргэдэд үзүүлэх үйлчилгээ чирэгдэлгүй, хялбар, шуурхай, хүнд сурталгүй болсон байна. | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Ай ти зон” компани 2019-2023 онд нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийг хөгжүүлэн 2024 оны 01 дүгээр сараас нэвтрүүлж эхэллээ.<br><br>2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш нийгмийн даатгалын цахим мэдээллийн шинэ системийг нэвтрүүлэх ажил үе шаттайгаар явагдаж, 2024 оны 03 дугаар сарын 15-наас төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал И-Монголиа системтэй холбон ажиллаж байна.<br><br>E-Mongolia цахим системд нийгмийн даатгалын 17 үйлчилгээг холбосон<br><br>e-Mongolia цахим системээс 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 14.8 сая удаа нийгмийн даатгалын цахим үйлчилгээг авсан байна.<br><br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/101 тушаалаар нийгмийн даатгалын үйлчилгээг их өгөгдөлд үндэслэн иргэдэд цахимаар үзүүлэх бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, “Үндэсний дата төв” УТҮГ, “И-Монгол академи” УТҮГ, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төлөөллийг оролцуулан байгуулсан.<br><br>Ажлын хэсэг 2024 оны 11 дүгээр сард 3 удаа хуралдаж, цахим хэлбэрээр үзүүлж байгаа нийгмийн даатгалын үйлчилгээний өнөөгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдал, тулгарч байгаа болон салбар хоорондын уялдааг хангах асуудлыг хэлэлцэж, хөдөлмөрийн чадвар алдсаны, ердийн болон олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг цахимаар авах ажлыг туршин хэрэгжүүлэхээр бэлтгэл хангаж байна. | |
| 39. | Эмнэлгийн хуудсыг цахимаар олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.<br>*/Алсын хараа-2050 3.1.5, МУЗГҮАХ 2020-2024 2.5.6, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.3/* | үйл ажиллагаан ы зардал | Цахим хуудас: 10 эмнэлэг<br><br>Чиглэл, зөвлөмжийн тоо-2 | 1200 эмнэлэг эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж байна. | Цахим эмнэлгийн хуудас бичдэг эмнэлгийн тоо 1300-д хүрсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудас буюу листийг цахимаар олгох шийдвэрийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудын ашигладаг E-Health системд хөгжүүлэлт хийж цахим лист олгох нөхцлийг бүрдүүлсэн. Бүх шатлалын эмнэлэг болон өрх, сумын эмнэлгүүд, хувийн эмнэлгүүдээс нийт 2350 эмнэлэг эмнэлгийн хуудсыг цахимаар олгож байна. Эмнэлгийн хуудсыг цахимаар олгох ажлыг зохион байгуулах талаар Эрүүл мэндийн яам болон Нийгмийн даатгалын ерөнхий газарт 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/431 тоот албан бичгээр чиглэл хүргүүлсэн. | 100 |
| 40. | Тэтгэврийн хувийн хэргийг үргэлжлүүлэн цахимжуулна.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.5, МУЗГҮАХ 2020-2024 2.5.6, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.3/* | үйл ажиллагаан ы зардал | Цахим хэлбэрт шилжүүлсэн хувийн хэргийн эзлэх хувь:10 хувь | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд нийт тэтгэвэр авагчдын 10%-ийн хувийн хэргийг цахим хэлбэрт шилжүүлсэн. | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын 10%-ийн хувийн хэргийг нэмж цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | Тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулж, иргэд, тэтгэвэр авагчдын тэтгэврийг цахимаар тогтоох, цахим хяналт, шалгалтыг сайжруулах, сумын төвөөс аймгийн төв рүү тэтгэврийн хувийн хэргийг шилжүүлэхгүй, зөөвөрлөх шаардлагагүй, нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүргэхээр баруун 8 аймгийн тэтгэврийн хувийн хэргийг 2022 оноос цахимжуулж бүрэн дууссан.<br><br>2024 оны 12 дугаар сарын байдлаар Дорноговь, Дорнод, Хөвсгөл, Дархан, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах ажлыг эхлүүлж 71 хувьтай байгаа бол, улсын хэмжээнд нийт цахимжуулах 165.2 мянган хувийн хэргээс 81 хувийг цахимжуулаад байна. | 100 |
| 41. | Салбарын хэлэлцээрүүдийг хууль тогтоомжийн дагуу бүртгэн, мэдээллийн санг бүрдүүлнэ. | үйл ажиллагаан ы зардал | Хянаж бүртгэсэн салбарын хэлэлцээрийн тоо | - | Салбарын хэлэлцээрүүдийг хянан бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд оруулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаа хангах, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлуудыг Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Засгийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газар салбарын хэлэлцээрүүдэд тусган хамтран ажиллаж байна.<br>Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дах хэсэгт заасны дагуу салбарын хамтын хэлэлцээрийг хянан бүртгэх, хуульд нийцээгүй тохиолдолд бүртгэхээс татгалзах эрхтэй.<br>Одоогийн байдлаар салбарын 13 хэлэлцээрийг хуулийн дагуу хянан бүртгэн баталгаажуулсан байна. | |
| 42. | Нийгмийн халамжийн цахим үйлчилгээний хөгжүүлэлтийг хийнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2020-2024 2.5.6, ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 5.5/* | үйл ажиллагааны зардал | Хөгжүүлэлт хийх үйлчилгээний тоо-3 | Нийгмийн халамжийн 64 төрлийн үйлчилгээг цахимжуулсан. E-mongolia цахим системд холбогдсон 1 үйлчилгээ. | Нийгмийн халамжийн цахим үйлчилгээний хөгжүүлэлтийг хийснээр нэр бүхий 3 үйлчилгээг и-монголиа цахим системтэй холбож, иргэд харьяалал харгалзахгүй үйлчилгээнд хамрагдах боломж бүрдсэн байна. | Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл болох насны хишиг, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмж, жирэмсэн эхийн тэтгэмжийн үйлчилгээг E-mongolia 4.0 шинэчлэгдсэн цахим системд холбосон. Ингэснээр иргэн дээрх 3 үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ төрийн байгууллагад биечлэн очилгүйгээр төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан хүсэлтээ өгөх боломж бүрдсэн. | 100 |
| 43. | Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, E-job платформын хөгжүүлэлтийг хийж хэрэглээнд нэвтрүүлнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2020-2024 2.5.6, 2.5.15 /* | Дэлхийн банкны ХЭДТөсөл-300 сая төгрөг | Мэдээллийн сан-1 | Онлайн портал, job matching буюу ажилд зуучлах үйлчилгээг нэвтрүүлсэн. | Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг туршиж, алдааг илрүүлж, сайжруулах ажлыг зохион байгуулж ажиллана. | "Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл"-ийн хүрээнд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр 2023 онд IT zone XXK-тай EJob системийн хөгжүүлэлтийг сайжруулах зорилгоор гэрээ байгуулж, гэрээний хугацаа 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр дууссан.<br>2024 оны 11 дүгээр сарын байдлаар "Ejob" платформд бүртгэлтэй ажлын байрны тоо–96672, ажил хайгчийн тоо–52760, ажилд зуучлагдсан иргэдийн тоо–26935, мобайл аппликэйшн хэрэглэгчийн тоо-10950 байна.<br>**Мэдээллийн сан-1** | 90 |
| 44. | Салбарын бүртгэл, статистикийн мэдээ, тайлангийн маягтуудын нэгдсэн стандарт загварыг мөрдүүлж, батлуулна. | үйл ажиллагааны зардал | Нийгмийн даатгалын статистикийн маягт, Хүүхдийн статистикийн маягтын тоо | статистикийн мэдээ, тайлангийн маягтуудын нэгдсэн стандарт загварын төсөл хийгдэж байгаа | Салбарын бүртгэл, статистикийн мэдээ, тайлангийн маягтуудын нэгдсэн стандарт загварыг мөрдүүлж, батлуулсан байна | Хүүхдийн эрх, хамгааллын статистикийн захиргааны маягт болон түүнийг нөхөх заавар, Хүүхдийн эрх, хамгааллын статистикийн бүртгэлийн маягт болон түүнийг нөхөх заавryг ХНХС-ын 2024 оны 03 сарын 29-ний А/60 дугаар тушаалаар батлуулсан.<br>Нийгмийн халамжийн сангийн захиргааны нэгтгэлийн маягт, түүнийг нөхөх заавryг батлах тухай А/35, А/36 дугаартай хамтарсан тушаалаар 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр батлуулсан.<br>Нийгмийн даатгалын салбарын захиргааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл цуглуулах маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлуулсан. | |
| 45. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын СТАТИСТИК-ийн нэгдсэн платформын үйл ажиллагааг тогтворжуулна. | үйл ажиллагаан ы зардал | Шинээр холбосон мэдээллийн сангийн болон мэдээллийн тоо | Мэдээллийн сангуудыг шинээр холбосон байна. | Өмнөх мэдээллүүдийг 2023 оны байдлаар шинэчилсэн байна. | Зорилтын хүрээнд Нийгмийн даатгалын сангаас үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллийг байршилаар болон нас, хүйс, олгосон мөнгөн дүнгээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар mlsp.gov.mn/report/31 хаяг дээр байршуулж байна.<br>Нийгмийн халамжийн үйлчилгээний ehalamj.mn систем болон хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем ejob.gov.mn-ийг холбож туршилтын дашбордын загваруудыг 2024 оны 04-р сарын байдлаар мэдээллүүдийг оруулсан.<br>Мөн ehalamj.mn системийг өрхийн мэдээллийн сантай тулгаж халамж авч байгаа иргэний мэдээллийг өрхөөр гарах нөхцөлийг бүрдүүлсэн. Цаашид нийгмийн даатгалын мэдээллийн систем шинэчлэгдсэн холбоотой мэдээллийн сангийн бүтцийг шинэчлэх, tableau системийг шинэчлэх шаардлагатай байна. | 100 |
| 46. | Асрамж, халамжийн төвүүд болон тэдгээрээр үйлчлүүлсэн иргэдийн нэгдсэн мэдээллийн санг бий болгож хяналтыг сайжруулна. | үйл ажиллагаан ы зардал | Систем Хөгжүүлэлтийг тоо | Системийн хөгжүүлэлтийн эхний шат эхэлсэн байна. | Асрамж, халамжийн төвүүд болон тэдгээрээр үйлчлүүлсэн иргэдийн нэгдсэн мэдээллийн санг бий болгож хяналтыг сайжруулна. | Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр тус системийг хөгжүүлэхээр Куантум Партнерс ХХК шалгарсан бөгөөд системийн хөгжлүүлэлт хийгдэж https://asramj.ehalamj.mn/ хаяг дээр байршуулаад байна.<br>Мөн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагуудыг хамарсан сургалт болон системийн хөгжүүлэгчийн сургалтуудыг тус тус зохион байгуулсан.<br>Цаашид системийг асрамжийн байгууллагуудын хэрэглэгчийн түвшинд нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. | 90 |
| 47. | Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны үр дүнг эцэслэн батлуулна. | үйл ажиллагаан ы зардал | Шинээр оруулсан мэдээллийн сангийн мэдээллийн тоо | Шинээр оруулсан мэдээллийн сангийн мэдээллийн тоо | Мэдээллийн сан бүрдүүлж бодлого, хөтөлбөрт ашигласан байна. | Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/16, А/04 хамтарсан тушаалаар батлуулсан аргачлалын дагуу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн–иргэнийг тодорхойлох амьжиргааны түвшний үнэлгээний оноог тогтоох зорилгоор 34,093 өрхийн 164,198 гишүүн-иргэний мэдээллийг ЭМДЕГ, ТЕГ, НДЕГ, ҮСХ зэрэг төрийн байгууллагуудын мэдээллийн сангаас шаадлагатай мэдээллийг ХУР системээр дамжуулан авч өрхийн амьжиргааг үнэлэх боломжийг бүрдүүлээд байна.<br>Мэдээлэл солилцох шаардлагатай талбарыг тодорхойлох мэдээлэл хариуцагчтай уулзалт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийх, албан бичиг төлөвлөн явуулах, системийг хөгжүүлж буй зөвлөхүүдийн тайлантай танилцах шаардлагатай тохиолдолд чиглэл хүргүүлэх зэрэг дэмжлэг үзүүлж ажиллав. | |
| ***1.5.2. Цахимжилт, мэдээллийн технологийн суурь болон хэрэглээний судалгаа хийх, цахимжилт, цахим үйлчилгээний бодлогын талаар иргэдэд мэдээлэл өгөх, олон нийтийн оролцоог хангах;*** | | | | | | | |
| 48. | Нийгмийн даатгалын сангуудын тогтвортой байдлыг хангаж байгаа эсэх талаар судалгаа хийнэ. | үйл ажиллагаан ы зардал | Мөнгөн урсгалын судалгаа-12 | Сар бүр нийгмийн даатгалын сангийн мөнгөн урсгалын тооцоо судалгааг хийж удирдлагуудад танилцуулдаг бөгөөд 2023 оны байдлаар нийт 12 судалгаа хийгдсэн. | Сар бүр нийгмийн даатгалын сангийн мөнгөн урсгалын тооцоо судалгаа хийж, нийгмийн даатгалын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, санал дүгнэлт боловсруулж удирдлагуудад танилцуулан, мэдээллээр хангасан байна. | Нийгмийн даатгалын сангийн мөнгөн урсгалын судалгааг нийгмийн даатгалын сан тус бүрээр 12 удаа хийж удирдлагуудад танилцуулсан. Энэхүү судалгааны зорилго нь нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төлөвлөгөөний гүйцэтгэлийг сар бүр хийж, нийгмийн даатгалын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, санал дүгнэлт гаргаж мэдээллээр хангах ач холбогдолтой юм. | 100 |
| 49 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдлын судалгааг хийнэ. | 15 сая төгрөг Улсын төсөв | -Удирдамж, аргачлал -1;<br>-Хэлэлцүүлэг -1;<br>-Тайлан -1 ; | Одоогоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдлыг судалсан судалгаа байхгүй байна. | -Судалгааг удирдамж, аргачлалын дагуу эхлүүлсэн байна.<br>-Судалгааг хийж дуусгасан байна.<br>-Судалгааг эцэслэн хэлэлцүүлж, тайлагнасан байна. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлын талаарх нэгдсэн судалгааг зохион байгуулах ажлын хэсгийг ХНХ-ын сайдын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/163 тоот тушаалаар байгуулж, удирдамжийг батлуулсан. Ажлын хэсэгт ХНХЯ-ны холбогдох газрын мэргэжилтнүүд болон судалгааны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагын төлөөлөл ажилласан. Судалгааны аргачлал боловсруулахад нийт 64,940,000 төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд МУИС-ын Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш нар болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ гэрээлэн гүйцэтгэсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын салбар комиссуудтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй 14,609 хүүхдийн судалгааг нас, хүйс, бэрхшээлийн төрөл хэлбэр, шаардлагатай онцлог хэрэгцээ, боловсролын үйлчилгээний чиглэлээр нарийвчлан гаргаж нэгтгэсэн.<br>Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хүнд хэлбэрийн хавсарсан эмгэгтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 2025 оноос эхлэн живхний үнийн хөнгөлөлт олгохтой холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт”-ын дагуу хөгжлийн бэрхшээлтэй 12, 077 хүүхдийн судалгааг өвчний жагсаалт бүрээр гаргаж, үүнээс хоёроос дээш насны живх байнга хэрэглэдэг хөгжлийн бэрхшээлтэй 3,009 хүүхдийн судалгааг нэгтгэн гаргасан. | |
| 50. | Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ХНХ-ын салбарт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй ажилтан албан хаагчдын нэгдсэн судалгаа гаргана. | үйл ажиллагаааны зардал | -Судалгаа -1;<br>-Сургалт, нөлөөллийн ажил -1;<br>-ХНХ-ын сайдын чиглэлийг салбарын бүх байгууллагуудад хүргүүлэх; | 2023 онд ерөнхий судалгаа гаргасан. | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, албан хаагчдын судалгааг нас, хүйс, бэрхшээлийн төрөл, албан тушаалын ангиллаар шинэчлэн, нэгтгэн гаргасан байна. | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, албан хаагчдын судалгааг нас, хүйс, бэрхшээлийн төрөл, албан тушаалын ангиллаар шинэчлэн, нэгтгэн гаргасан 2024 оны 3 дугаар сарын байдлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 331 хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч ажиллаж байна. | 90 |
| 51. | Салбарын хэмжээнд Ахмадын сан байгуулсан, Ахмад ажилтныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллагын нэгдсэн судалгаа гаргана. | үйл ажиллагааны зардал | -Судалгаа -1;<br>-Сургалт, нөлөөллийн ажил -1;<br>-ХНХ-ын сайдын чиглэлийг салбарын бүх байгууллагуудад хүргүүлэх; | Нэгдсэн судалгаа байхгүй. | -Салбарын хэмжээнд Ахмадын сан байгуулсан, Ахмад ажилтныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллагын нэгдсэн судалгаа гаргасан байна. | Ахмад настны тухай хуулийн 14.6-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ.” гэж заасан. Мөн хуулийн 14.7-д дээрх арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулна гэж заасан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас ХХҮЕГ, НДЕГ, ХБХХЕГ Ахмадын сан байгуулан, хуулийн дагуу ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах үйл ажиллагаанд зарцуулан ажиллаж байна.<br>Аж ахуйн нэгж, байгуул-лагуудыг “Тэтгэвэрт бэлт-гэх” төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, хэвшүүлэхэд Монголын ахмадын холбоо, төв, орон нутгийн байгуул-лагууд санаачилгатай ажиллаж эхний хагас жилд 650 аж ахуйн нэгж байгууллага төлөвлөгөө гаргасан нь хүрэх түвшнээс 50 хувиар илүү байна. Нийслэлд 115 аж ахуйн нэгж байгууллага, аймаг орон нутагт 435 аж ахуйн нэгж байгууллага тэтгэвэрт гарах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Тэтгэвэрт гарах насны ахмад настнуудад тэтгэвэрт гарах сэтгэл зүйн бэлтгэлтэй байх, тэтгэвэрт гараад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ямар ажил эрхлэх боломжтой талаар зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх материалын бүрдлийг хэрхэн хангасан байх, ахмад ажилтны ажлын туршлага, мэдлэг чадварыг нь залуу хойч үед зааж сургах гэх мэт олон төрлийн үйл ажиллагааг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. | |
| ***2. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ*** | | | | | | | |
| ***2.1. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХАД СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ, ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, ӨРГӨЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.1-ИЙН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| ***2.1.1. Бодлогын үр нөлөөг үнэлэх, үр дүнг хэмжих, шалгуур үзүүлэлтийг боловсруулах*** | | | | | | | |
| 52. | Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийнэ. | Олон улсын байгууллагын санхүүжилт | -Төлөвлөгөө-1;<br>-Тайлан-1;<br>-Үнэлгээ-1; | 2021 оны 07 дугаар сарын 02-нд батлагдсан Хөдөлмөрийн тухай хууль, дагалдан гарсан 20 дүрэм, журам | Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан байна | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг 2024 оны 06 дугаар сараас 2024 оны 10 дугаар сарын 21-ний хооронд орон нутагт бүсчлэн зохион байгуулахаар ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/134 дугаар тушаалаар ажлын нэгдсэн удирдамж болон хуваарийг баталсан. Хуваарийн дагуу Хөдөлмөрийн тухай болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг Баян-Өлгий болон Завхан, Архангай аймагт ажилласан.<br><br>Үзлэгийн нэгдсэн дүнг улсын хэмжээнд 12 дугаар сарын 25-ны дотор нэгтгэн гаргахаар удирдамжид тусгасан. | 100 |
| 53. | Ажилтан, ажил олгогч нарт зориулан хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцлөөр ажиллах уламжлалт бус хөдөлмөр эрхлэлтийн хөдөлмөрийн гэрээний загварыг боловсруулна. | үйл ажиллаганы зардал | Гэрээний загвар | Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээний загвар | Гэрээс, зайнаас, бүтэн бус цагаар гэх мэт гэрээний загварыг боловсруулж харьяа газар, хэлтсээр түгээсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/114 дүгээр тушаалаар Дагалдангаар ажиллах хөдөлмөрийн гэрээний жишиг загвар, дагалдангаар суралцах хөдөлмөрийн гэрээний жишиг загвар, туршилтаар ажиллах хөдөлмөрийн гэрээний жишиг загвар, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний жишиг загвар, гэрээсээ ажиллах хөдөлмөрийн гэрээний жишиг загвар, зайнаас ажиллах хөдөлмөрийн гэрээний жишиг загвар, иргэд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хооронд байгуулах хөдөлмөрийн гэрээний жишиг загварыг тус тус баталсан. Уг загварын англи хэл дээрх албан бус орчуулгыг боловсруулж, олон нийтэд түгээхээр бэлдэж байна. Түүнчлэн нэмэлт 3 төрлийн хөдөлмөрийн гэрээний жишиг загварыг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн талуудаас санал авч нэгтгээд байна. | |
| 54. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг сонгосон салбарт хийнэ. | ҮОМШӨДС 10.0 сая төгрөг | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ | Боловсролын салбарт ХАБЭА-н тухай хуулийн улсын үзлэгийг зохион байгуулсан. | Нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллалагад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийж, үнэлгээг ХАБЭА-н Үндэсний хороонд танилцуулж, зөвлөмж гаргасан байна. | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг 2024 оны 06 дугаар сараас 2024 оны 10 дугаар сарын 21-ний хооронд орон нутагт бүсчлэн зохион байгуулахаар ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/134 дугаар тушаалаар ажлын нэгдсэн удирдамж болон хуваарийг баталсан. Хуваарийн дагуу Хөдөлмөрийн тухай болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг Баян-Өлгий болон Завхан, Архангай аймагт хийсэн. Үзлэгийн нэгдсэн дүнг удирдамжийн дагуу улсын хэмжээнд 12 дугаар сарын 25-ны дотор нэгтгэн гаргахаар ажиллаж байна. | 100 |
| 55. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2021-2030)-ний хэрэгжилтийг хангана. | үйл ажиллагаан ы зардал | Тайлан-1 | ЖҮХ-ны 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 2 дугаар тогтоолоор стратеги төлөвлөгөөг баталсан. | Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний “Эдийн засгийн хүрээнд жендэрийн тэгш боломж, тэгш оролцоог хангах” зорилгын хэрэгжилтийг хангах Дэд ажлын хэсэг ГБХНХ-ын сайдын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/61 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан. Мөн ТНБД-ын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 03/886 дугаар албан бичгээр уг зорилгын хүрээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагуудаас авч, нэгтгэн боловсруулав. МУ-ын Ерөнхий сайдын ахалсан Ажлын хэсгийн хурал 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулагдаж, уг зорилгын хэрэгжилтийн тайлан, үр дүнг танилцуулав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 56. | УИХ-ын чуулганд өргөн мэдүүлэх хуулийн төсөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлын жагсаалтыг улирал тутам гарган ЗГХЭГ-т хүргүүлэх ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагаан ы зардал | Жагсаалт-4 | Улирал тутам гарган ЗГХЭГ-т хүргүүлсэн. | УИХ-ын чуулганд өргөн мэдүүлэх хуулийн төсөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлын жагсаалтыг улирал тутам гарган хүргүүлсэн байна. | УИХ-ын намрын чуулганд өргөн мэдүүлэх хуулийн төсөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлын жагсаалтыг 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар гарган ХЭЗХ-ээс ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |
| ***2.2.МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖИЛ ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, НИЙГМИЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН САЛБАР ДУНДЫН ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ЦОГЦ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ГЭР БҮЛ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.3-ЫН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| ***2.2.1.Хүүхдийн хөгжил, хамгаалал, хүн амын бүлгүүдийн цогц хөгжил, оролцоог хангах, эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж, стратегийн бодлогыг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах;*** | | | | | | | |
| 57. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2018-2024 оны стратегийн хэрэгжилтийг хангана. | үйл ажиллагаан ы зардал | Тайлан-1 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2018-2023 оны стратегийн хэрэгжилтийн тайлан гарсан. | 2024 оны хэрэгжилтийн тайланг гаргасан байна. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлого /2018-2024/-ын хэрэгжилтийн тайланг нэгтсэн боловсруулаад байна. Уг тайланд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, салбарын шатны бодлогын төслийг боловсруулах ажлыг 2025 оны 1 дүгээр улиралд Жендэрийн үндэсний хорооны ажлын албатай хамтран зохион байгуулах юм. | 100 |
| ***2.3.ЭРЭЛТЭД НИЙЦСЭН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗӨВ, ОНОВЧТОЙ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ, ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЦАЛИН ХӨЛСНИЙ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ЗӨВШЛИЙН ГУРВАН ТАЛТ БОЛОН БУСАД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.4-ИЙН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| ***2.3.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг боловсронгуй болгох, ажил олгогч, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд үр дүнг дээшлүүлэх;*** | | | | | | | |
| 58. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ /хөтөлбөр/-ний хэрэгжилтийг зохицуулах, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хяналт тавьж, зөвлөмж гаргуулна. | ХЭДС 58.4 сая төгрөг | Үнэлгээний тайлан – 1; Арга хэмжээ-1; | 2023 оны Хөтөлбөрийн хэрэгжилтэд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс зөвлөмж гаргасан. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ /хөтөлбөр/-ний 2024 оны хэрэгжилтэд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хяналт тавьж, зөвлөмж гаргуулна. Хөтөлбөрийн хэрэгжилтэд зохицуулалтаар хангасан байна. | 2024 оны төсвийн гүйцэтгэлийг гишүүдэд танилцуулан санал авч 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлтөд тусган ажиллаж байна. Хөдөлмөрийн эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хурлыг 1 дүгээр сарын 2 дахь 7 хоногт багтаан хийхээр төлөвлөсөн болно.<br>**Төсвийн гүйцэтгэлийн танилцуулга-1** | 90 |
| 59. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн | үйл ажиллагаан ы зардал | Төсвийн төсөл – 1; Тушаал – 1; | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн төслийг | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн хязгаарыг боловсруулах хүрээнд УИХ-аар 2024 оны 6 сарын 5-ны өдөр батлагдсан | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуваарийн тооцоо судалгаа хийх, санал дүгнэлт боловсруулах, төсвийн хуваарийг батлуулна. | | | 2024 оны төсвийн төсөл боловсруулагдсан. | холбогдох газартай хамтран боловсруулсан байна<br><br>ХЭҮЗ-ийн саналыг үндэслэн ХЭДС-ийн хуваарийг батлуулсан байна. | Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд шинээр нэмэгдсэн ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний төсвийг орлого болон зарлагын талд нь тус тус нэмж тусгав. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны нийт зарлагын хэмжээг төсвийн хязгаарт 150.0 тэрбум төгрөг байхаар, давхардсан тоогоор 183,778 иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил, жижиг аж ахуйн нэгжийг хөтөлбөр, арга хэмжээнд хамруулахаар тооцсон.<br>**Төсвийн хуваарийн төсөл-1** | |
| ***2.3.2.Ажиллах хүч гадаадаас авах, гаргах бодлогыг зохицуулах, гадаадаас буцаж ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;*** | | | | | | | |
| 60. | Ажил олгогчийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулалтаар хангана. | ХЭДС<br>12 тэрбум төгрөг | Журам -1;<br>Хамрагдсан иргэн, ААН тоо; | шинэ арга хэмжээ | Цалингийн урамшууллыг 3000 иргэнд олгохоор аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулахад зохицуулалтаар хангасан байна. | Тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт чиглэл хүргүүлсэн. Уг арга хэмжээний зардлыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд тусгаж 5200 хүнийг хамруулахаар ажиллаж байна. 21 аймаг 9 дүүргийн ХХҮГ, хэлтсүүдийн хөдөлмөрийн асуудал хариуцсан хэлтэс, албадын дарга болон мэргэжилтнүүдтэй энэхүү арга хэмжээний талаар цахимаар сургалт зохион байгуулж ажилласан. Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд менежментийн дэмжлэг үзүүлэх зорилгоор "Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төсөлтэй хамтран менежментийн баг томилон ажиллуулж байна. Ажил олгогчийг дэмжих туршилтын төсөлд нийт **20 аж ахуйн нэгж, байгууллага 25 мэргэжлээр 88 дагалдан ажилтан** тогтвор суурьшилтай ажиллаж байна. | 90 |
| 61. | Монгол Улсад 2025 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна. | үйл ажиллагааны зардал | Засгийн газрын тогтоолын төсөл-1 | Монгол Улсад 2024 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 360 дугаар тогтоол | Монгол Улсад 2025 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан байна. | "Монгол Улсад 2025 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.<br>**ЗГ-ын тогтоол-1** | 100 |
| ***2.3.3. Зохистой ажлын байр бий болгохыг дэмжих, хөдөлмөр эрхлээгүй иргэнийг ажлын байраар хангах, ядуурлыг бууруулах арга хэмжээний хөтөлбөр, төсөл боловсруулах;*** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 62. | “Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд бодлого арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллана. | үйл ажиллагаан ы зардал | Хамрагдах оролцогчийн тоо-700 хүртэл | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 4-р тогтоолоор “Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”-ийг баталсан. | -“Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн бүхий л үйл ажиллагааг удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажилласан байна.<br>-Монгол Улсын хэмжээнд 700 ажилгүй иргэнд хөдөлмөр эрхлэх суурь болон мэргэжлийн ур чадвар олгосон байна. | ХНХЯ ХНХСҮСИ хооронд Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн С2-CS-2023-10/03/53 дугаартай гэрээ байгуулсан. ХНХСҮСИ мэргэжлийн ур чадвар олгох сургалтыг нийслэлийн төвийн 6 дүүргийн хүрээнд (I шат) 14 мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж **11 мэргэжлээр нийт 329** иргэнийг сургалтад хамруулсан. Үүнээс төгсөлтийн үнэлгээнд 299 суралцагч чадамжийн гэрчилгээ авсан.<br>Мэргэжлийн ур чадвар олгох сургалтын II шатыг орон нутгийн 21 аймаг, алслагдсан 3 дүүргийн хүрээнд 7 байршил (Баян-Өлгий, Ховд, Орхон, Дархан-Уул, Сүхбаатар, Төв аймаг, Налайх дүүрэг)-д 9 мэргэжлээр **нийт 317** иргэн хамрагдсан байна.<br>**Оролцогчийн тоо-646** | 100 |
| 63. | “Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах” тухай журмыг боловсруулж батлуулна. | үйл ажиллагаан ы зардал | Журам-1 | шинэ арга хэмжээ | Монгол Улсын Их Хурлын чуулганаар 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Боловсролын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 26 дугаар зүйлийн 26.1.3 заалтад “Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах” гэж, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Эзэмшсэн мэдлэг, ур | Журмын төслийг сайжруулах дахин боловсруулах шаардлагын дагуу Боловсролын яамтай хамтран ажлын хэсэг байгуулахаар тохирсон.<br>Уг ажлын хэсэгт яамыг төлөөлж оролцох албан тушаалтны нэрсийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны 03/1267 тоот албан бичгээр хүргүүлсэн. Журмын төслийг Боловсролын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институттэй хамтран боловсруулж байна.<br>**Журмын төсөл-1** | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чадварыг үнэлж, баталгаажуулах зохицуулалтыг Хөдөлмөрийн тухай хуулийн 17.4-т заасны дагуу хэрэгжүүлнэ" гэж, мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дах заалтад Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдээр хамтран батлуулна. | | |
| ***2.3.4. Хөдөлмөрийн маргаанаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн маргаан урьдчилан шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх, хөгжүүлэх;*** | | | | | | | |
| 64. | Хөдөлмөрийн маргаан зохицуулалтын асуудлаар мэдээллийн сан үүсгэх санал боловсруулна. | Олон улсын байгууллагын санхүүжилт | Санал-1 | "Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм", "Хөдөлмөрийн арбитрын дүрэм", "Хөдөлмөрийн сонирхлын маргааныг хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр зохицуулах журам", "Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны дүрэм"-ийн хэрэгжилт | Хөдөлмөрийн маргаан зохицуулалтын асуудлаар мэдээллийн сан үүсгэх санал боловсруулсан байна. | Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн сонирхлын маргааны бүртгэлийн маягт, маягт нөхөх зааврыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний А/29 дүгээр тушаалаар батлуулав. Батлагдсан маягтын дагуу хөдөлмөрийн сонирхлын маргааны 2023 оны мэдээг нэгтгэн 2024 оны 03 дугаар сарын 22-нд ҮСХ-нд 03/735 тоот албан бичгээр хүргүүлэв. Хөдөлмөрийн маргаан зохицуулалтын асуудлаар мэдээллийн сан үүсгэх асуудлаар цаашид ОУХБ-тай хамтран ажиллахаар төлөвлөж байна. | 90 |
| 65. | "Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд нийгмийн түншлэлийн оролцоо" сэдэвт | Олон улсын байгууллагын санхүүжилт | Хөтөлбөр-1; Хэлэлцүүлэг-1; | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийг | МҮЭХ, МАОЭНХ,МҮХАҮТ зэрэг байгууллагатай хамтран үндэсний хэмжээний | Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны удирдлага, төлөөлөлтэй 02 дугаар сарын 22-ний өдөр "Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны Улсын хэлэлцээр"-ийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гурван талт хэлэлцүүлэг хийнэ. | | | хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө | хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. | хэрэгжилтийн талаар санал солилцох уулзалтыг зохион байгуулсан. Уг уулзалтаас Ерөнхий сайд "Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт харилцааг бэхжүүлэх, хамтын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг сайжруулах" Засгийн газрын өргөтгөсөн хуралдаан хийхээр шийдвэрлэсэн. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулан албажуулсан. Тэмдэглэлд хууль, эрх зүйн шинэчлэл хийх, нийгмийн түншлэлийн хороо, зөвлөлийн санхүүжилтийг шийдвэрлэх, хамтын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан. | |
| 66. | Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | ХЭДС 925.0 сая төгрөг | Хөтөлбөр-1 | Шинээр хийх ажил | Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолоор "Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр" батлуулав. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2024 оны төсвийн хуваарийн 3.5.1-ийн 6 дугаарт уг хөтөлбөрийн зардал 968,1 сая төгрөг тусган батлагдсан.<br>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Мэргэшсэн зөвлөх"-үүдийг бэлтгэх сургалтыг 2024 оны 5, 11 дүгээр сард 2 удаа зохион байгуулж нийт 63 "Мэргэшсэн зөвлөх" бэлтгэв.<br>"Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр"-ийг нийслэлийн төвийн 6 дүүрэгт тус хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд 40 гаруй аж ахуйн нэгж, байгууллагаас хөтөлбөрт хамрагдах хүсэлт ирүүлсэн байна.<br>Дээрх байгууллагуудаас 20 аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг давхардсан тоогоор 34 зөвлөх хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж, 26 баримт бичгийг боловсруулан өгч, арга зүйгээр хангаж байна. Зөвлөх үйлчилгээнд барилга, тавилга, оёдол болон хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдсан байна. | 100 |
| ***2.4. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ХЭТИЙН ТӨЛВИЙГ ХАРГАЛЗСАН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.5-ЫН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| ***2.4.1.Нийгмийн даатгалын хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;*** | | | | | | | |
| 67. | Гадаад улстай нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан хэлэлцээрийн | үйл ажиллагаан ы зардал | Зохион байгуулсан ажил /ОХУ, БНСУ, БНУУ, БНТУ, БНЧУ, БНПУ-ын нийгмийн | ОХУ, БНЧУ, БНПУ, БНСУ-ын нийгмийн хамгааллын хэлэлцээртэй | Хэлэлцээрийн хэрэгжилтийг зохицуулах ажлын хүрээнд мэдээлэл, чиглэл, зөвлөмж | Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн мэдээлэл, зөвлөмж бүхий танилцуулга бэлтгэж Гадаадын иргэн харьяатын газарт хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг зохицуулна.<br><br>*/НДТ хуулийн 2 дугаар зүйлийн 2./* | | хамгааллын хэлэлцээр/-2;<br><br>Судалгаа-1; | холбоотой 9 ажил зохион байгуулж ажилласан. | боловсруулж, Консулын газар, Гадаад харилцааны яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газарт хүргүүлсэн байна. Судалгаа шинжилгээ хийж, санал боловсруулсан байна. Судалгаанд суурилж танилцуулга мэдээлэл бэлтгэсэн байна. | “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээний хүрээнд хилийн чанад дахь Монголчуудад хийсэн цахим сургалт, нийгмийн хамгааллын хэлэлцээрийн тухай мэдээллийг Гадаад харилцааны яаманд 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 04/638 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Гадаад харилцааны яам, Гадаадын иргэн, харьяатын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газарт 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 03/246 тоот албан бичгээр хүсэлт хүргүүлэн Монгол Улсад ажиллаж, амьдарч буй гадаад иргэдийн нэгдсэн судалгааг гаргаж, танилцуулга мэдээлэл бэлтгэн удирдлагуудад танилцуулсан. | |
| 68. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулах зорилгоор Засгийн газрын тогтоол болон бусад журам, дүрэм, заавар боловсруулна.<br><br>*/ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 3.2/* | үйл ажиллагаан ы зардал | Боловсруулж, батлуулсан тогтоол, шийдвэрийн тоо-5 | Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд дагаж гарах дүрэм, журмыг боловсруулж батлуулсан. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах Засгийн газрын тогтоол болон бусад шийдвэр боловсруулж батлуулсан байна. | 1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т “Итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тогтоож, дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөнө” гэж заасны дагуу 2024 онд хэрэглэх итгэлцүүрийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Итгэлцүүр тогтоох тухай” 10 дугаар тогтоолыг батлуулсан.<br><br>2.“Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын 4.9 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын хэлтэс” гэснийг “Нийгмийн даатгалын газар” гэж өөрчлөлт оруулахаар Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 15 дугаар тогтоолыг батлуулсан.<br><br>3.Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар "Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай" 14 дүгээр тогтоолыг батлуулсан. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах талаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт 2024 оны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03/251 тоот албан бичгээр чиглэл хүргүүлсэн.<br><br>4.Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны 18 маягтын загвар болон түүнийг хөтлөх аргачлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/44, А/40 дүгээр хамтарсан тушаалаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6770 дугаарт бүртгүүлсэн.<br><br>5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/113 дугаар тушаалаар “Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах журам”-ыг нэгдүгээр, Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлуулсан.<br><br>6. Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах харилцааг зохицуулсан журам батлах тухай” 256 дугаар тогтоолыг батлуулсан.<br><br>7.Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар ”Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журам батлах тухай” 254 дүгээр тогтоолыг батлуулсан.<br><br>8.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус мэргэжлийн хорооны ажиллах журам батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл болон журмын төслийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлуулсан.<br><br>9.Даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлэх, сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлуулсан.<br><br>10.Орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрмийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулсан.<br><br>11.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус мэргэжлийн хорооны ажиллах журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлуулсан.<br><br>12.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний зааврыг Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/293, А/133 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан.<br><br>13.Ажил олгогчид ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлуулсан.<br><br>14.Ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хяналт тавих журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлуулсан.<br><br>15.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлуулсан.<br><br>16.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ”Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлал батлах тухай” 75 дугаар тогтоолыг батлуулсан.<br><br>17.”Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх мэргэжлийн хорооны гишүүнд олгох урамшууллын хэмжээг тогтоох тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлуулсан.<br><br>18.”Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүнд олгох урамшууллын хэмжээг тогтоох тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 12 дугаар тогтоолоор батлуулсан.<br><br>19.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, журмыг Нийгмийн бодлогын байнгын хорооны Байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулсан. | |
| 69. | Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалт зохион байгуулна. | үйл ажиллагаан ы зардал | Сайдын тушаал-1 | Жил бүр зохион байгуулж байна. | Улсын байцаагчийн эрх шинээр олгох, эрх баталгаажуулах, эрх цуцлах, түдгэлзүүлэхтэй холбоотой сайдын тушаал батлагдсан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 38.3, 38.4 дэх хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргад Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн А/38 дугаар тушаалыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллав.<br><br>Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/40 дүгээр тушаалаар баталсан. Шалгалтыг 2024 оны 11 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Энэ удаагийн шалгалтад нийт 299 байцаагч хамрагдаж, 162 байцаагч, ажилтан шалгалтад тэнцсэн.<br><br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох тухай” А/69 дүгээр тушаал, “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх баталгаажуулах тухай” А/70 дугаар тушаал, “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цуцлах тухай” А/71 дүгээр тушаал “Мэргэшлийн зэрэг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай” А/72 дугаар тушаалыг тус тус батлуулж, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 04/1665 тоот албан бичгээр Нийгмийн даатгалын ерөнхий газарт чиглэл хүргүүлж ажилласан | |
| ***3. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ*** | | | | | | | |
| ***3.1. МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖИЛ, ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, НИЙГМИЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН САЛБАР ДУНДЫН ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ЦОГЦ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ГЭР БҮЛ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.3-ЫН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| ***3.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;*** | | | | | | | |
| 70. | Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтэд НҮБ-аас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангана. | үйл ажиллагааны зардал | -Ажлын хэсгийн тушаал-1<br>-Хэлэлцүүлэг-2<br>-Төлөвлөгөө-1 | Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын Монгол Улсын 2 болон 3 дугаар тайланг НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонд 2023 оны 08 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд хэлэлцүүлсэн. | -Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна.<br>-Холбогдох байгууллагуудад үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал авах тухай албан тоот хүргүүлж, мэдээллийг нэгтгэсэн байна.<br>-Төлөвлөгөөний төслийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлд хэлэлцүүлэн санал авсан байна.<br>-2024 оны төлөвлөгөөг яамд, агентлаг, Засаг дарга нарт хүргүүлж, хэрэгжүүлсэн байна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон хорооноос Монгол Улсад ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулах салбар дундын ажлын хэсгийг 2024 оны 06 дугаар сард байгуулсан.<br>Ажлын хэсгээс “Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжүүдийг 2025-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж, 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>Төлөвлөгөөний төсөл, Засгийн газрын тогтоол, тэмдэглэл, танилцуулгын хамт боловсруулан Засгийн газрын гишүүдээс санал авахаар албан бичгээр хүргүүлж, одоогийн байдлаар 7 яамнаас санал ирүүлсэн байна.<br>ЮНЕСКО байгууллагатай хамтран 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын талаарх ойлголт болон НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн “Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн Хорооноос хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт 2015, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2023 онуудад ирүүлсэн зөвлөмжийн гарын авлага"-ыг боловсруулж, түгээсэн. | |
| 71. | Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилгыг ашиглалтад хүлээн авна.<br><br>*/МУЗГҮАХ 2020-2024 2.5.8, МУХТЖҮЧ 2021-2025 2.3.4/* | АХБ-ын хөнгөлөлттэй зээл 22.2 тэрбум төгрөг | -Тушаал-1<br>-Засгийн газрын тогтоол-1 | Барилгын явц 75 хувь. | -Төвийн барилгыг ашиглалтад хүлээн авсан байна.<br>-Төв байгуулах тухай ЗГ-ын тогтоол батлуулсан байна.<br>-Төвийн дүрэм, бүтэц орон тоог сайдын тушаалаар батлуулсан байна.<br>-Төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн байна. | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд Улаанбаатар хот дахь "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв"-ийг барьж, 2024 оны 06 дугаар сард ашиглалтад оруулж, хүлээн авсан.<br>Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв" Улсын төсөвт үйлдвэрийн газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяанд байгуулахаар шийдвэрлэж, төвийн дүрмийг тогтоолын хавсралтаар баталсан.<br>Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн бүтэц, орон тоог батлах тухай ГБХНХ-ын сайдын тушаалын төслийг боловсруулж, санал авах тухай албан бичгийг холбогдох байгууллагуудад албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| ***3.1.2. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, гэр бүлийн гишүүдийн эрх, үүрэг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах;*** | | | | | | | |
| 72. | Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 дугаар тушаалаар батлагдсан "Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах журам"-ыг шинэчлэн батлуулна.<br><br>*(Хүн худалдаалахтай тэмцэх тухай 12.1.3, МУЗГҮАХ-ийн 4.3.5)* | үйл ажиллагааны зардал | Журам-1 | Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 дугаар тушаал | Журмын төслийг шинэчлэн батлуулж, 21 аймаг, 9 дүүрэгт чиглэл хүргүүлсэн байна. | Тахарын алба татан буугдаж, тус журмыг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага татан буугдсантай холбоотой тус журмыг шинэчлэх шаардлага үүссэн. Иймээс тус яамнаас Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 дугаар тушаалаар батлагдсан "Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах журам"-ыг шинэчлэн боловсруулж, батлах хэрэгцээ шаардлага үүссэн. Энэ хүрээнд "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/39 дүгээр тушаалаар хүчирхийллийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах чиглэл батлагдаад байна. Эдгээртэй уялдуулж журмын төслийг боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны "Журам батлах тухай" А/40 дүгээр тушаалаар баталлаа. | 100 |
| 73. | Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нийтлэг | үйл ажиллагааны зардал | Стандарт-1 | Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний | -Стандартыг шинэчлэн батлуулсан байна. | Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нийтлэг шаардлага MNS6040: 2019 стандартыг | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлага MNS 6040: 2019 стандартыг шинэчлэн батлуулна. | | | нийтлэг шаардлага MNS 6040: 2019 стандарт | -Стандартыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ТХБ-д хүргүүлсэн байна. | шинэчлэн батлуулахаар стандартын төслийг боловсруулаад байна. | |
| 74. | ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайд, ЭМ-ийн сайдын 2017 оны А/173, А/251, А/3801 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ыг шинэчлэн батлуулна. | үйл ажиллагаан ы зардал | ХНХС, ХЗДХС, ЭМСайдын хамтарсан тушаал-1 | Журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр сургалт зохион байгуулсан. | ХНХС, ХЗДХС, ЭМСайдын 2017 оны А/173, А/251, А/3801 дугаар хамтарсан тушаалыг шинэчлэн батлуулсан байна. | ХНХС, ХЗДХС, ЭМСайдын 2017 оны А/173, А/251, А/3801 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ын төслийг боловсруулж, улсын хэмжээнд шат дараалсан хэлэлцүүлэг хийсэн. Төслийг Эрүүл мэндийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд руу 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/1075 албан тоотоор хүргүүлсэн болович Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцэгдэж байгаатай холбогдуулан түр хүлээх чиглэлийг ирүүлсэн. Хүүхэд хамгааллын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор “Журам батлах тухай” ХНХСайд, Сангийн сайдын 2024 оны А/06, 17 дугаар тушаалаар “Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүнд нэмэгдэл урамшуулал олгох тухай” журмыг баталсан. | 100 |
| ***4. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ*** | | | | | | | |
| ***4.1. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХАД СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ, ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, ӨРГӨЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.1-ИЙН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| ***4.1.1. Салбарын гадаап хамтын ажиллагааг эрхэлж, гадаад орон, олон улсын байгууллага, төощрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх;*** | | | | | | | |
| 75. | Монгол Улс, гадаад улс хоорондын хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр хэлэлцээр болон санамж бичиг байгуулахад зохицуулалтаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Улс орноо гадаадад сурталчлах зардал | -Боловсруулсан баримт бичгийн тоо<br>-Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт зэрэг чиглэлээр хамтран ажилласан улс орны тоо | Удирдлагын тохиролцоо, холбогдох хэлэлцээрт гарын үсэг зурахтай холбоотой бэлтгэл ажлыг хийж байгаа | Боловсруулсан хэлэлцээрийн төслийг холбогдох яаманд хүргүүлэх, хэлэлцээ хийсэн байна. | Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хооронд Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах асуудлаар шинжээчдийн түвшинд ажиллаж байгаа ба шинжээчдийн ажлын хэсгийн эхний уулзалт, хэлэлцээрийн төсөл, Удирдлагын тохиролцоо, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төсөл, Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төсөл, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд “Жайпур фут” төслийн хүрээнд Хамтран ажиллах тухай санамж бичгийг 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр гарын үсэг зурсан зэргийг тус тус орчуулж, харилцааг зохицуулалтаар хангаж, хамтран | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласан. Монгол Улс нэгдэж орсон олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зөвлөмжүүдийн 2024 онд 7 конвенцын тайланг хүргүүлсэн. Бүгд Найрамдах Киргиз Улсын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг айлын талтай эцэслэн тохиролцож хамтран ажилласан. Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмын дагуу хянуулж, санамж бичиг байгуулах зөвшөөрөл авахаар ГХЯ-нд 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/1034 албан тоотоор хүргүүлсэн. ГХЯ айлын талд албан ёсоор хүргүүлж ажилласан болно. Өндөр дээд түвшний айлчлалын үеэр үзэглэхээр төлөвлөгдсөн. НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2023-2027 оны хамтарсан Улс орны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024-2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд санал авч, батлуулахад дэмжлэг үзүүлэн, зохион байгуулалтаар хангаж ажиллав. Монгол Улсын уул уурхайн салбар болон бусад аж үйлдвэрийн салбарын ажилтны хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх, нийгмийн хамгааллыг бэхжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор АНУ-ын Хөдөлмөрийн яамтай Хөдөлмөрийн хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагааг хамтран зохион байгуулав. | |
| 76. | НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | Улс орноо гадаадад сурталчлах зардал | Чуулган болон бага хурлын бэлтгэл болон оролцохтой холбоотой арга хэмжээнүүдийг ёслол протоколын дүрэм журамд нийцүүлэн, холбогдох хууль тогтоомж болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахина. | Чуулган, бага хурлын арга хэмжээнд төлөөлөгч оролцсон | Чуулган, бага хуралтай холбогдох төлөөллүүд батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу оролцон, холбогдох бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна. | НҮБ-ын Ерөнхий Ассамблей, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын хорооны чуулган, НҮБ-ын Нийгмийн хөгжлийн хорооны чуулган, НҮБ-ын Хүн ам ба хөгжлийн хорооны чуулган, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн хорооны залуучуудын чуулга уулзалт, Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурлын Чуулган /Женев/, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын бүсийн Бага Хурал, "Ази Номхон далайн хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагааны байгууллага"-аас зохион байгуулж буй "Дэлхийн тэтгэвэр, нийгмийн хамгаалал, үндэсний баялгийн сангийн дээд хэмжээний уулзалт (2024 APIC World Pension, Social Security and Sovereign Wealth Funds Summit)", Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, НҮБ-ын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтран зохион байгуулсан “Бээжин+30”-ын хэрэгжилтийн талаарх Ази, Номхон далайн бүс нутгийн Сайд нарын хурал, Бүгд Найрамдах Колумби Улсын Богота хотод зохион байгуулагдсан “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох асуудлаарх дэлхийн сайд нарын анхдугаар хурал”-д тус тус оролцсон. | |
| ***4.2.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ, ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХУУЛЬ ТОГТООМЖ СУРТАЛЧЛАХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.2-ЫН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| ***4.2.1. Хууль тогтоомж болон салбарын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, энэ талаар холбогдох байгууллага, орон нутгийн нэгжийн ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах:*** | | | | | | | |
| 77. | Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны 4 бодлогын баримт бичигт хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний биелэлт гаргах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагаан ы зардал | Урт, дунд, богино хугацааны 4 бодлогын баримт бичгийн тайлан-11 | Тайланг тухай бүр хуулийн хугацаанд <u>сар бүр</u>, <u>хагас, бүтэн жилээр гаргасан.</u> | Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны 4 бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцын тайланг баримт бичиг тус бүрээр сараар, хагас бүтэн жилээр нэгтгэн боловсруулж, нийт 16 биелэлтийг ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | 1/ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын 50 арга хэмжээний хэрэгжилтийн явцын тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>2/ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 24 арга хэмжээний хэрэгжилтийн явцын тайланг 2024 оны жилийн эцсийн байдлаар гарган ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>3/-Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн 47 зорилт, арга хэмжээний биелэлтийг эхний хагас жилд сар бүр нэгтгэн, үнэлгээ хийлгүүлэхээр тус яамны ХШҮДАГ-т хуулийн хугацаанд хүргүүлэв.<br>-Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 57 зорилтын 105 арга хэмжээний хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар гарган ХШҮДАГ-т хүргүүлэв.<br>4/ Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 13 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган ХШҮДАГ-т хүргүүлэв.<br>-Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтийг 1 дүгээр хавсралтаар;<br>-Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн хэрэгжилтийг 2 дугаар хавсралтаар;<br>-Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний хагас, бүтэн жилийн үзүүлэлтийг 3 дугаар хавсралтаар тус тус гарган ХШҮДАГ-т заасан хугацаанд багтаан хүргүүлэв. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 78. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | -Тайлан -12;<br>-ЗГХЭГ-ын ХШҮДАГ-аас ирүүлсэн жагсаалтын дагуу заалт, арга хэмжээ тус бүрээр; | -2023 онд нийт 15 удаа тайлан гаргасан. Үүнд:<br>1/2023 онд сар бүр буюу 12 удаа гаргасан.<br>2/Нэмэлтээр нийт 3 удаа 698 заалт, арга хэмжээний биелэлт гаргасан. Үүнд:<br>**-3 дугаар сард** 195 арга хэмжээ /ЗГХЭГ-т/,<br>**-5 дугаар сард** 46 арга хэмжээ /ЕСайдын үүрэг даалгавар-ЦХХХЯ-нд/,<br>**-10 дугаар сард** 351 заалт, арга хэмжээ /ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газарт/ | Тайланг сар бүр нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ЗГХЭГ-с ирүүлсэн жагсаалтын дагуу 2024 онд сар бүр буюу 12 тайланг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд багтаан ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>Тухайлбал, 2024 онд нийт 2500 орчим /давхардсан тоогоор/ заалтын биелэлтийг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд багтаан ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br><br>Тухайлбал, 2024 онд нийт давхардсан тоогоор 2500 орчим заалтын биелэлтийг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд багтаан ХШҮДАГ-т хүргүүлэв. | 100 |
| 79. | ХНХЯ-ны 2023 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн биелэлт гаргах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | ХНХЯ-ны 2022 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн Тайлан-1;<br>-2022 оны зорилтот түвшингийн гүйцэтгэлийг үзүүлэлт тус бүрээр; | Жил бүр тайлан гаргадаг. | Тайланг нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | ХНХЯ-ны 2023 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 19 үзүүлэлтийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн. | 100 |
| ***4.2.2. Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын стратегийг тодорхойлж, хэрэгжилтийг зохицуулан, нэгдсэн удирдлагаар хангах, гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулах, биелэлтийг үнэлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;*** | | | | | | | |
| 80. | Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, түүний хэрэгжилтийн тайланг гаргах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | -Яамны 2024 оны гүйцэтгэлийн Төлөвлөгөө-1;<br><br>-Тайлан-2; | -Төлөвлөгөөний төслийг боловсруулж, Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | -Төлөвлөгөөг МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичиг /урт, дунд, богино хугацааны/ холбогдох хууль тогтоомж болон салбарын стратеги төлөвлөгөөтэй уялдуулсан байна. | <u>*Эхний хагас жилд:*</u><br><br>-ХНХЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 тоот тушаалын 3 дугаар хавсралтын дагуу боловсруулж, газруудын саналыг тусган, Төрийн нарийн бичгийн дарга болон Төрийн захиргааны удирдлагын газрын даргад танилцуулан, Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэв. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | */ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 4.3./* | | | -Тайланг хагас, бүтэн жилээр гарган, ХШҮДАГ-т хүргүүлсэн. | -Төлөвлөгөөнд газруудын саналыг тусган, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан байна.<br><br>-Тайланг хагас, бүтэн жилээр хуулийн хугацаанд нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | ХНХЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, “Алсын хараа-2050” зэрэг бодлогын баримт бичигт хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээтэй уялдуулав.<br>Яамны үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд 144 арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөв. Үүнд**:**<br>• Бодлогын баримт бичигт тусгагдсан 52 арга хэмжээ;<br>• Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 16 арга хэмжээ;<br>• Хуулиар олгосон чиг үүргийг үүргийг хэрэгжүүлэх 6 арга хэмжээ<br>• Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 54 арга хэмжээбайна.<br>• Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 16 арга хэмжээ.<br>Мөн түүнчлэн Засгийн газрын 2023 оны 231-р тогтоолоор баталсан “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө /2023-2027 он/-нд хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр дэвшүүлсэн 45 зорилт, арга хэмжээг яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хавсаргав.<br><br>-ХНХЯ-ны 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Хавсралтын хамт газруудаас авч, нэгтгэн, ХШҮДАГ-т хүргүүлэв.<br><br>*Сүүлийн хагас жилд:*<br><br>-Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнд хамтарсан Засгийн газар байгуулагдаж, Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 37 дугаар тогтоолоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан. ЗГ-ын энэхүү тогтоолын дагуу тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн А/20 дугаар тушаалаар яамны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан.<br>Иймд дээрх шийдвэрүүдэд нийцүүлэх зорилгоор ГБХНХЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын болон нэгжийн нэршил, тэдгээрийн стратегийн зорилтуудад холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн батлуулсан.<br>ГБХНХЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 155 арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд**:**<br>• Бодлогын баримт бичигт тусгагдсан 51 арга хэмжээ;<br>• Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 18 арга хэмжээ;<br>• Хуулиар олгосон чиг үүргийг үүргийг хэрэгжүүлэх 5 арга хэмжээ<br>• Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 65 арга хэмжээбайна.<br>• Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 16 арга хэмжээ.<br><br>-ГБХНХЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг нэгтгэн, ХШҮДАГ-т хүргүүллээ. | |
| 81. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ГБХНХЯ-ны үйл ажиллагааны төлөвлөгөөний тухайн жилийн биелэлтийг гаргах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагаан ы зардал | Тайлан-1 | 2023 оны жилийн эцсийн байдлаар тайланг гаргасан. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ХНХЯ-ны үйл ажиллагааны төлөвлөгөөний тухайн жилийн биелэлтийг газруудаас авч нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | ГБХНХ-ын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ГБХНХЯ-ны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2024 онд хэрэгжүүлсэн 73 арга хэмжээний биелэлтийн тайланг нэгтгэн, ХШҮДАГ-т хүргүүллээ. | 100 |
| 82. | Байгууллагын 2023 оны ил тод байдлын хэрэгжилтийг гаргах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагаан ы зардал | Тайлан-1 | 46 заалт арга хэмжээний хэрэгжилтийг жил бүр гаргадаг. | Тайланг хуулийн хугацаанд нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | Байгууллагын 2023 оны ил тод байдлыг хангах 46 заалтын хэрэгжилтийг хуулийн хугацаанд гарган, ХШҮДАГ-т хүргүүлэв. | 100 |
| 83. | ГБХНХЯ-ны сар бүрийн үйл ажиллагааны тайланг боловсруулж ЗГХЭГ-т | үйл ажиллагаан ы зардал | -Тайлан -12;<br>-“Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” | 2023 онд 1-12 сарын 12 тайланг тухай бүр гарган, (www.unelgee.gov .mn)-д хугацаанд | ХНХЯ-ны 2024 оны 1-12 сарын үйл ажиллагааны тайланг гарган, “Засгийн газрын хяналт- | 2024 оны 1-12 сарын үйл ажиллагааны тайлангуудыг тухай бүр нэгтгэн боловсруулж, ЗГ-ын ХШҮ-ний цахим системд хуулийн хугацаанд багтаан байршуулж, баталгаажуулав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүргүүлэх ажлыг зохион байгуулна. | | (www.unelgee.gov.mn)-д хугацаанд нь байршуулж баталгаажуулах; | нь байршуулж баталгаажуулсан. | шинжилгээ, үнэлгээний цахим систем” (www.unelgee.gov.mn)-д хугацаанд нь байршуулж баталгаажуулсан байна. | Тайланг хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бодлого төлөвлөлтийг сайжруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, санхүү, хөрөнгө оруулалт, дотоод ажил, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэсэн 6 чиглэлээр, гүйцэтгэсэн ажлыг тулгамдсан болон хоцорч буй ажил, УИХ, ЗГ-т өргөн барьсан, салбарын хүрээнд хийгдсэн болон шинэлэг ажил гэсэн 4 төрлөөр тус тус гарган хүргүүлж ажиллав.<br>2024 онд 12 сарын хугацаанд нийтдээ 940 арга хэмжээг нэгтгэсэн байна. | |
| ***4.2.3. Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, олон нийттэй харилцах:*** | | | | | | | |
| 84. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөл /ТАСЗ/-ийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана. | үйл ажиллагаан ы зардал | -ТАСЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө-1;<br>- Хэрэгжилт; | -Төлөвлөгөө-1,<br>-Тайлан-1; | -Төрийн албаны салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан байна.<br>-Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.<br>-Тайланг ТАЗ-д хүргүүлсэн байна. | Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлөөс салбарын хэмжээний төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх, төрийн үйлчилгээний удирдах албаны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зохион байгуулах комиссыг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тухай бүр байгуулан ажилллалаа.<br>Энэ онд Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлөөс яам, агентлаг, харьяа байгууллагын удирдах 38, гүйцэтгэх 202 нийт 240 сул орон тооны тусгай шалгалтыг зохион байгууллаа.<br>Тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулав.<br>Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сул орон тоог олон нийтэд мэдээлэх, төрийн жинхэнэ албан хаагч төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах боломжийг хангах үүднээс уг албан тушаалд ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5 хоногийн хугацаанд Зөвлөлийн цахим хуудас, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системээр мэдээлэн ажиллаж байгаа бөгөөд журам батлагдсанаас хойш нийт 240 сул орон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тооны мэдээллийг салбарын хэмжээнд нэгтгэн нийтэд мэдээлсэн байна.<br>Төрийн албаны зөвлөлөөс энэ оны 9 дүгээр сард Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаад салбарын бусад яамдаас 4 дахин их сонгон шалгаруулалт зохион байгуулж байгаа, салбар зөвлөлийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдаж байна гэж дүгнэсэн. | |
| 85. | Төсвийн ерөнхийлөн захирагчаас харъяа байгууллагын дарга, захиралтай хамтран ажиллах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавина. | үйл ажиллагаан ы зардал | Хамтран ажиллах гэрээ | Жил бүр | -Төсвийн ерөнхийлөн захирагчаас харъяа байгууллагын дарга, захиралтай Хамтран ажиллах гэрээ байгуулахыг зохион байгуулсан байна.<br>-Гэрээний биелэлтийг хүлээн авч, ХШҮДАГ-т хүргүүлсэн байна. | Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа агентлагууд, байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, албажуулах ажлыг зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу 2024 оны эхний хагас жил болон жилийн эцсийн Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газраар үнэлүүлэх ажлыг зохион байгууллаа. | 100 |
| 86. | ГБХНХЯ-ны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах дунд хугацаа (2022-2025 он)-ны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авна.<br><br>*/ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 4.2./* | үйл ажиллагаан ы зардал | Хөтөлбөрийн хэрэгжилт | ХНХЯ-ны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах дунд хугацаа (2022-2025 он)-ны хөтөлбөрийг Төрийн нарийн бичгийн даргын 2022.11.22-ны А/235 тушаалаар шинэчлэн баталсан. | “Нийгмийн баталгаа хангах дунд хугацаа (2022-2025 он)-ны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Төрийн албан хаагчдын Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ оны эхний хагас жилд Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу 2024 оны эхний хагас жилээр 144 албан хаагчид холбогдох журмын дагуу урамшуулал олгосон байна. Ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн шахуу хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэн илүү цагаар ажилласан албан хаагчдад цалингийн санд багтаан илүү цагийн хөлсийг тооцож олгох Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын дагуу 10 албан хаагчид илүү цагийн хөлсөнд 3,5 сая төгрөгийг тооцож олголоо. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд төрийн албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардалд өдрийн 3 мянга, өдрийн хоолны мөнгөнд 25 мянган төгрөгөөр тооцон, сар бүр олгохоор өөрчлөлт орж, эхний хагас жилд 249,1 сая төгрөг олгосон байна.<br>Мөн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шинээр гэр бүл болсон 1 ажилтанд 800 мянган төгрөг, ар гэрт нь гачигдал гарсан 9 ажилтанд 5.6 сая төгрөг, өөрийн зардлаар мэдлэг боловсролоо дээшлүүлэхээр их дээд сургуульд суралцаж байгаа 3 ажилтанд 2.4 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон. | |
| 87. | Бодлого, үйл ажиллагаа, цаг үе, үйл явдлын мэдээ мэдээллийг шуурхай бэлтгэн мэдээллийг хүртээмжтэй ил тод байдлаар олон нийтэд хүргэнэ.<br>Байгууллагын вэб сайт болон сошиал сувгуудыг хөтөлж, хөгжүүлнэ. | үйл ажиллагаан ы зардал | Нийгмийн сүлжээ болох Фэйсбүүк хуудас, твиттер, инстаграмд тогтмол мэдээ, постер видео хэлбэрээр олон нийтэд хүргэх мэдээллийг оруулан хөгжүүлж хөтлөх | Фэйсбүүк хуудасны дагагчдын тоо 106,000 байна. | Вэб сайтад цаг үе үйл явдлын 300 аас доошгүй мэдээ мэдээлэл байршуулж, байнгын идэвхтэй үйл ажиллагааг хангана. Фейсбүүк пэйжийн дагагчдын тоог 10 мянгаар нэмэгдүүлсэн байна. | -Байгууллагын вэб сайтад эхний хагас жилд 130 мэдээ, сүүлийн хагас жилд 170, нийт **300** орчим /үйл явдлын мэдээ, ярилцлага, видео мэдээ/ бэлтгэн байршуулсан.<br>-Нийгмийн сүлжээ болох Фэйсбүүк хуудас, твиттер тогтмол мэдээ, постер видео хэлбэрээр олон нийтэд хүргэх мэдээллийг оруулан хөгжүүлж хөтөлж байна. Тухайлбал, Фэйсбүүк хуудаст өдөрт дунджаар 8-9 пост /мэдээ, постер, видео контентууд г.м/ оруулж ажилласан ба дагагч, хандалтын тоо тогтмол өсч, оны эхнээс дагагчдын тоо 9200 гаруйгаар нэмэгдэж **118387** болсон байна.<br>Gov.mn вэб сайтад нийтлэгчийн админ эрх нээлгэж, яамны 8-12 сарын хугацаанд болсон бүхий л үйл явдлын мэдээ болох **140** орчим мэдээг байршуулах ажлыг хийж гүйцэтгэв. | 100 |
| 88. | Байгууллагын ил тод байдлыг хангах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна. | Олон нийтэд сурталчлах зардал | Байгууллагын ил тод байдлыг ханган хэвлэл мэдээллийн байгууллагаас тавьсан хүсэлтийн дагуу мэдээлэл өгөх, хамтран ажиллах | Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж хамтран ажилласан. | Тавьсан хүсэлтийн дагуу тухай бүр мэдээлэл тодруулга өгч, ил тод байдлыг хангасан байна. | -Удирдлагаас өгсөн чиглэлийн **8** байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэ хүрээнд гэрээний төсөл, ажлын даалгавар боловсруулан холбогдох тушаал шийдвэрийг гаргуулав.<br><br>-Гэрээтэй байгууллагуудтай хамтран яамны бодлого, үйл ажиллагааны талаар мэдээ мэдээллийг түгээж ажиллав.<br><br>Гэрээтэй байгууллагуудаас тайланг нэгтгэн авч, дүгнэлт тайлан бичиж, гэрээг дүгнэн, үлдэгдэл санхүүжилтийг олгуулав.<br><br>-Мөн яамнаас зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, аянд хэвлэл мэдээллийн байгууллагуудыг урьж мэдээ тодруулга сурвалжилга тогтмол хийлгэж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Байгууллагын ил тод байдлыг хангах хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагаас тавьсан хүсэлтийн дагуу яамны удирдлагууд болон мэргэжилтнүүдээр давхардсан тоогоор **200** гаруй удаа яриа тодруулга өгүүлэв.<br><br>-Цаг үеийн шинжтэй мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор Ийгл, МҮОНТВ-ийн Зочны цаг нэвтрүүлэгт 5 удаа дэд сайд, газрын дарга нарыг оролцуулж тодруулга мэдээлэл өгөв.<br><br>МҮОНТВ-ийн Нийгмийн хэлэлцүүлэг, Олон нийтийн цаг зэрэг нэвтрүүлгийг бэлтгэхэд хамтран оролцож, нийгмийн даатгалын багц хууль, хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд өргөн хүрээний мэдээлэл өгч ажиллав.<br><br>Боловсрол суваг телевизийн шинэ төсөл болох “Edutaiment weekly” хөтөлбөртэй хамтран 11 сарын 22 ны өдөр 1 цагийн шууд нэвтрүүлэг хийв. Нэвтрүүлэгт Б.Батжаргал дарга, НДҮЗ ийн мэргэжлийн хорооны гишүүн Ч.Өнөржаргал нарыг оролцуулж, нийгмийн даатгалын хуулийн талаар мэдээлэл түгээлээ. | |
| 89. | Яамнаас зохион байгуулах нэгдсэн арга хэмжээний мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагаан ы зардал | Аян, өдөрлөг, хурал зөвлөгөөн зэрэг нэгдсэн арга хэмжээний мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах | -Ажлын хэсэгт орж ажилласан.<br>-Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг оролцуулсан.<br>-Мэдээ сурвалжилга бэлтгэн түгээсэн. | Мэдээллийн хүртээмжтэй байдлыг ханган өргөн хүрээнд мэдээлсэн байна | -Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй оны шилдгүүдийг шалгаруулах арга хэмжээний мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулав. Арга хэмжээнд хэвлэл мэдээллийн байгууллагуудыг урьж **16** мэдээллийн суваг ирж сурвалжилсан.<br><br>-Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” үндэсний 2 дугаар чуулганы мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг өргөнөөр оролцуулж, сурталчлав.<br><br>-Залуучуудын хөгжлийн үндэсний чуулганы арга хэмжээний мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулав. Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг өргөнөөр оролцуулсанаас гадна 2 студитэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, 6 пэйж хуудсаар өндөр чанартай, дохионы хэлмэрчтэйгээр шууд дамжуулалтыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Мөн арга хэмжээний үеэр богино видео контентыг тасралтгүй бэлтгэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түгээж ажилласан. Энэ хүрээнд 10 гаруй видео контент бэлтгэгдсэн.<br><br>-Хөдөлмөрийн зах зээлийн 2035 он хүртэлх эрэлт, нийлүүлэлтийн таамаглалыг танилцуулах өглөөний уулзалт арга хэмжээнд хэвлэл мэдээллийн 11 байгууллагыг урьж ирүүлэн мэдээ мэдээллийг түгээж ажиллав.<br><br>-Хөдөлмөр эрхлэлт 2024 арга хэмжээний мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулав.<br><br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдрийг угтсан арга хэмжээнүүдийг зохион байгуулах хүрээнд ЭШБХ, Төрийн ордонд зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоо 2024” үндэсний чуулган, “Абиллити экспо 2024” арга хэмжээ зэрэг томхон арга хэмжээний мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулж, мэдээлэл бэлтгэх, контент бүтээх, гэрэл зураг авах, контент багт зөвлөн туслах зэрэг ажлыг хийж гүйцэтгэв. Ман арга хэмжээнүүдэд хэвлэл мэдэллийн байгууллагуудыг урьж сурталчилгаag өргөн хүрээнд зохино байгуулсан.<br><br>-Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулганы ажлын хэсэгт орж ажиллан, мэдээлэл ёурталчилгааны ажлыг ГХЯ, ЕТГ-ын хэвлэл мэдээллийн албатай хамтран зохион байгуулав.<br><br>-Гамшгаас хамгаалах команд штабын сургалтын мэдээ мэдээллийг шуурхай бэлтэн түгээж ажилласан ба давхар дадлага сургуулилт хийсэн болно. | |
| 90. | Салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэл, дүрэм журам, заавар, цахимжуулалтын талаар олон нийтэд ойлголт мэдээлэл өгнө. | Олон нийтэд сурталчлах зардал | Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хуулийн төсөл, дүрэм, журмыг олон нийтэд хүргэх | - | Хуулийн зүйл заалтыг ойлгомжтой хүртээмжтэй хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байна. | Нийгмийн даатгалын багц хуулийн талаар олон нийтэд мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, постер зэргээр дамжуулан ойлголт мэдээлэл өгөх ажлыг тасралтгүй зохион байгуулсан. Энэ хүрээнд МҮОНТВ тэй хамтран Олон нийтийн цаг 20 минутын нэвтрүүлгийг бэлтгэн түгээв. ХНХ-ын Дэд сайд С.Зулпхарын ярилцлагыг бэлтгэн “Өдрийн сонин”-д нийтлүүлэв.<br>Хүүхэд хамгааллын тухай хуулийн онцлох зохицуулалтын талаар мэдээ постер бэлтгэн түгээв. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Хүүхэд хамгааллын тухай хуулийн талаар МҮОНТВ ийн “Олон нийтийн цаг” 20 минутын нэвтрүүлэг , мөн 20 минутын Зочны цаг нэвтрүүлэгт дээрх сэдвээр дэд сайд С.Зулпхарыг оролцуулав.<br>Хүүхэд хамгааллын тухай хуулийн талаар хэвлэл мэдээлэлд мэдээ тодруулга өгч түгээх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулав.<br>-Нийгмийн даатгалын багц хуулийг дагаж гарах журам, дүрэм, заавар боловсруулах батлах ажлын талаар тогтмол мэдээлж ажилласан.<br>-Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн талаар,<br>“Эхийн алдар" одонтой мөнгөн тусламжийн хэмжээг ирэх онд нэмэх талаар,<br>Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс нэмэхээр болсон зэрэг Засгийн газраар хэлэлцэн баталсан журам тогтоолын талаар тухай бүр өргөн хүрээнд мэдээлж ажилласан.<br>Мөн Ахмад настны тухай болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн талаар зэрэг эрх зүйн шинэчлэлийн талаар тогтмол мэдээлсэн болно.<br>УИх-д өргөн барихаар төлөвлөж буй, болон боловсруулж буй хуулийн төслийн явц, санал авах хэлэлцүүлэг зэргийг тухай бүр мэдээлж ажиллав | |
| ***4.2.4. Яамны аппаратын хэвийн үйл ажиллагааг хангах*** | | | | | | | |
| 91. | ГБХНХЯ-ны дотоод ажлыг тухай бүр шуурхай зохион байгуулах арга хэмжээ авна. | үйл ажиллагаан ы зардал | Яамны дотоод хэвийн үйл ажиллагааг хангах | Тухай бүр хэрэгжүүлж ажилласан. | Яамны дотоод ажлыг тухай бүр шуурхай хангаж ажилласан байна. | -ГБХНХ-ын Сайдын-1, Төрийн нарийн бичгийн даргын-12 удаагийн шуурхай хуралдааныг зохион байгуулж, хурлын тэмдэглэл хөтлөн, шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг яамны газар, нэгжүүдээс нэгтгэн ТНБД-д тухай бүр танилцуулж ажиллав.<br>-ГБХНХ-ын Сайд яамны ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулав. /наян нас гарсан, гавьяат цол хүртсэн 5 ахмад настнууд болон ахмадын өдрийг угтан, 60 гаруй ахмад настнуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэв. /<br>-ГБХНХ-ын салбарын хүрээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, гамшгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аюулын үед салбарын бэлэн байдал, тогтвортой ажиллагааг хангаж ажиллах, гамшгаас хамгаалах “Команд штабын сургууль”-ийг 2024 оны 11 дүгээр сарын 11-12- ны өдрүүдэд зохион байгуулах бэлтгэл ажлын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж ажиллав.<br>-ГБХНХ-ын салбарын Удирдах ажилтны зөвлөгөөн байгуулах тухай 2024 оны 11 сарын 27-ны өдрийн А/50 дугаар сайдын тушаалыг батлуулан, 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж ажиллав. | |
| 92. | ГБХНХЯ-ны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна. | үйл ажиллагаан ы зардал | -Яамны газар, нэгжүүдээс 2023 болон 2024 оны эхний хагас жилд гарсан архивын баримтуудыг хүлээн авч, архивын нэгж үүсгэн хадгалалт, хамгаалалтад авах;<br>-Газар, хэлтсүүдийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлуулах:<br>-Архив, албан хэрэг хөтлөлтийн 2019 оны улсын үзлэгийн үеэр өгсөн зөвлөгөө болон 2023 оны хяналт, шалгалтаас өгсөн Зөвлөмжийг хэрэгжүүлэх;<br>-Засгийн газрын 2022.12.07-ны өдрийн хуралдааны 58 дугаар тэмдэглэлийн дагуу Албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллах; | -Жил бүр архивын баримтуудыг хүлээн авч, архивын нэгж үүсгэн хадгалалт, хамгаалалтад авдаг.<br>-Газар, хэлтсүүдийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангасан.<br>-ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны тушаалаар ажлын хэсэг байгуулж 2023.09.04-11.04 хугацаанд харъяа байгууллагуудын архивч нараар 2000 оноос хойшхи баримт бичгийг бүртгэл данстай болгож цэгцлэх ажлыг хийлгэсэн. | -Яамны газар нэгжүүдээс 2023 болон 2024 оны эхний хагас жилд гарсан архивын баримтуудыг хүлээн авч, архивын нэгж үүсгэн хадгалалт, хамгаалалтад авсан байна.<br>-Газар, хэлтсүүдийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангасан байна.<br><br>-Архив, албан хэрэг хөтлөлтийн 2019 оны улсын үзлэгийн үеэр өгсөн зөвлөгөө болон 2023 оны хяналт, шалгалтын Зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байна.<br><br>-Албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажилласан байна. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны газар нэгжүүдээс 2023 онд хөтлөгдөж дууссан баримтыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг үндэслэн архивт хүлээн авах хуваарийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлуулсан<br>Баримт нягтлан шалгах комиссыг ГБХНХЯ-ны Төрийн нарийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/155 тоот тушаалаар шинэчилсэн.<br><br>Хадгалах хугацаа нь дууссан устгах бичгийг ялгах, шаардлагатай зарим төрлийн баримтыг нягтлан шалгах байгууллагын БНШК-оор хэлэлцүүлэн ҮТА-ын арга зүйчээр хянуулах талаар мэдээлэл зөвлөгөө авч устгах акт үйлдэж устгах арга хэмжээ авах санал хүргүүлсэн.<br>Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-д заасан стандартын шаардлага хангасан 218 боть баримтыг шалган хүлээн авч, үдэж хавтаслан архивын нэгж үүсгэн хадгалалт хамгаалалтад авч данс бүртгэл үйлдэх ажлыг хуваарийн дагуу хийж байна.<br>Яамны газар, хэлтэс, иргэд, байгууллагын хүсэлтээр УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэр, Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаал шийдвэр болон шаардлагатай баримтын хуулбарыг 98 удаа, Шүүхээс шаардсан нотлох баримтыг 5 удаа гарган өгч, архивын сан хөмрөгөөс 5 боть баримтыг түр өгч ашиглуулсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***4.2.5. Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;*** | | | | | | | |
| 93. | -Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд судалж, шийдвэрлүүлнэ.<br>-Мэдээ, тайланг ЗГХЭГ-т хүргүүлнэ. | үйл ажиллагаан ы зардал | Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд судалж, шийдвэрлүүлэх; хяналт тавих; | Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн мэдээг 7 хоног, сар бүр гарган, хяналт тавин ажилласан. | -Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд судалж, шийдвэрлүүлэн, хяналт тавьж сар бүр мэдээ гаргасан байна.<br>-Мэдээ, тайланг улирал тутам ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Гэр бүл, хөдөлмөр ,нийгмийн хамгааллын яам болон харьяа агентлагуудад иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал тутамд гаргаж Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.<br>Тус яаманд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1494 өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээлэл ирүүлсэнээс 842 бичгээр, цахимаар, иргэд олон нийттэй харилцах төвөөс 641, биечлэн болон утсаар 11 ирсэн байна. Үүнээс 1440 өргөдөл шийдвэрлэж, 54 өргөдөл шийдвэрлэх шатандаа, хугацаа болоогүй байна. Шийдвэрлэлт 96,4 хувьтай байна. | 90 |
| 122. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийн саналыг холбогдох агентлаг, газар, хэлтсээс хүлээн авч нэгтгэн боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлж төсвийн тухай хуульд тусгуулах, 2024 оны гүйцэтгэлийг тайлагнана. | - | Тоо: Төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн санал 1<br>Чанар: Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийн төлөвлөгөөний төслийг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх, батлагдсан шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангаж ажиллаж гүйцэтгэлийг тайлагнах | | Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийн төлөвлөгөөний төслийг боловсруулсан холбогдох байгууллагад хүргүүлж, батлагдсан шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг тайлагнасан байна. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийн саналыг холбогдох агентлаг, газар, хэлтсээс хүлээн авч нэгтгэн боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төслийн хамт УИХ, Сангийн сайд, Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны жилийн эцэс, 2024 оны эхний хагас жилийн "Хөтөлбөрт зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайланг гарган Сангийн яам, Үндэсний Аудитын газарт хүргүүлж ажилласан. | 100 |
| 123. | Төсвийн тухай хуулийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсвийн ерөнхийлөн захирагч 2025 онд аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах "Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулах гэрээ"-нд тусгагдах төсвийн мэдээллийг боловсруулна. | - | Тоо: 22<br>Чанар: Гэрээний хавсралтад тусгагдах төсвийн саналыг харьяа агентлаг, яамны холбогдох газруудаас авч нэгтгэн боловсруулах | | Хавсралтыг боловсруулж гэрээ хийх нөхцөлөөр хангасан байна. | ТЕЗ-аас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээний хавсралтыг төсвийн тухай хуулийн хүрээнд боловсруулан бэлтгэж, гэрээний хавсралтанд тусгахаар бэлтгэсэн. | 100 |
| 124. | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг төсөвт байгууллагад | - | Тоо: 1<br>Чанар: УСНББОУС, Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалыг мөрдүүлэх | | Салбарын нягтлан бодогч, санхүүгийн ажилтнуудыг мэргэжил арга зүйн | 2023, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Э-тайлангийн системд илгээх талаарх сургалтыг харьяа агентлаг, байгууллагуудын нягтлан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мөрдүүлэх, бүртгэлийн программ хангамж болон бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан санхүүгийн ажилтнуудыг чадавхижуулна. | | | | удирдлагаар ханган ажилласан байна. | бодогч нарт зориулан нийтдээ 2 удаа зохион байгуулж заавар зөвлөгөө өгч ажиллалаа. | |
| 125. | Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж салбарын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг олон нийтэд мэдээлнэ. | - | Тоо<br>Чанар: Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийг ханган мэдээллийг шилэн дансанд байршуулах | | Салбарын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтай холбогдох мэдээллийг хууль, журамд заасан хугацаанд шилэн дансанд байршуулсан байна. | ТЕЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн аудитлагдсан тайлан, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, Үндэсний Аудитын газраас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт, 2023 оны 12-р сар, 2024 оны 01-11 саруудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг shilendans.gov.mn сайтад байршуулж байна. | 100 |
| ***Зорилт 2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн сар, улирлын болон хөтөлбөр, арга хэмжээний хуваарилалт хийх, захиран зарцуулах, тайлагнах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зохицуулалтаар хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх;*** | | | | | | | |
| 126. | Харьяа байгууллага болон Засгийн газрын тусгай сангуудыг батлагдсан төсвийг хуваарилалт хийх, санхүүжүүлэх, салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд төсөвт өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлыг зохион байгуулна. | 3.956.7 тэрбум төгрөг | Тоо, хэмжээ: 1<br>Чанар: Батлагдсан хуваарийн дагуу санхүүжилт олгож, шаардлагатай тохиолдолд төсөвт өөрчлөлт оруулах санал боловсруулан Сангийн яамны холбогдох газар, хэлтэст хүргүүлэх | | Төсөвт байгууллага, тусгай сангийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн хүрээнд олгож салбарын хэвийн үйл ажиллагааг хангаж шаардлагатай нөхцөлд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах санал хүргүүлж тусгуулсан байна. | Харьяа агентлаг, төсөвт байгууллагуудаас ирүүлсэн төсвийн сар, улирлын хуваарьт зохицуулалт хийх, төсвийн тодотголд тусгах шаардлагатай саналуудыг нэгтгэн хянан холбогдох зохицуулалтыг хийж шийдвэрлэлээ.<br>Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай болон Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг нэгтгэн боловсруулж Сангийн яаманд 2024 оны 07 р сарын 19-ний 01/02 дугаар албан бичгээр хүргүүлсэн ба тодотголоор батлагдсан төсвийн шинэчилсэн хуваарийг байгууллагадуудад хүргүүлэн заавар чиглэл өгөн, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангаж ажиллалаа. Мөн хүрэлцэхгүй дутагдалтай байгаа зарим зардлуудын гүйцэтгэлийг хянан үзэж, хүндрэлтэй байгаа бичиг хэргийн зардал, БҮТЭЗ, багаж техник хэрэгсэлийн зардлуудыг шийдвэрлэж нийт салбарын хэмжээнд 2,3 тэрбум төгрөгийн зохицуулалтыг хийж шийдвэрлэн өр төлбөргүй ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 127. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийн хэрэгжилтийг хангаж өр төлбөр үүсгэхгүй байх, 2024 оны эхний хагас жил, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хууль, журмын дагуу нэгтгэн боловсруулж, аудитын дүгнэлт гаргуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Тоо, хэмжээ: Нэгтгэсэн тайлан, аудитын дүгнэлт, танилцуулга бүхий 2 тайлан.<br>Чанар: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд аудит хийлгэж дүгнэлт гаргуулах, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг холбогдох хууль, журмын хүрээнд гаргаж Сангийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлэх | | - Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд аудит гаргуулж Сангийн яаманд хуулийн хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.<br>- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг холбогдох хууль, журмын хүрээнд гаргаж Сангийн яаманд хүргүүлсэн байна. | Харьяа агентлаг, төсөвт байгууллагуудаас ирүүлсэн төсвийн сар, улирлын хуваарьт зохицуулалт хийх, төсвийн тодотголд тусгах шаардлагатай саналуудыг нэгтгэн хянан холбогдох зохицуулалтыг хийж шийдвэрлэн ажиллалаа.<br>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай болон Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг нэгтгэн боловсруулж Сангийн яаманд 2024 оны 07 р сарын 19-ний 01/02 дугаар албан бичгээр хүргүүлсэн ба тодотголоор батлагдсан төсвийн шинэчилсэн хуваарийг байгууллагадуудад хүргүүлэн заавар чиглэл өгөн, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангаж ажиллалаа. Мөн хүрэлцэхгүй дутагдалтай байгаа зарим зардлуудын гүйцэтгэлийг хянан үзэж, хүндрэлтэй байгаа бичиг хэргийн зардал, БҮТЭЗ, багаж техник хэрэгсэлийг зардлуудыг шийдвэрлэж нийт салбарын хэмжээнд 2,3 тэрбум төгрөгийн зохицуулалтыг хийж шийдвэрлэн өр төлбөргүй ажилласан. | 100 |
| 128. | Харьяа байгууллага, тусгай сангуудын өдөр тутмын гадаад, дотоод зарлагын гүйлгээг сар улирлын хуваарийн дагуу хянан баталгаажуулах, зарцуулалтыг батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлэн зардлын хэтрэлт, өр, авлага гаргахгүй байх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хянан баталгаажуулж Сангийн яаманд хүргүүлнэ. | - | Тоо 12<br>Чанар: Төсвийн тухай хуулийн 8.8-д заасан цаглабарын дагуу төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээнд хяналт тавих, дүн шинжилгээ хийж, хэтрэлт хэмнэлт, өр авлагын мэдээллийг нэгтгэн боловсруулах | | Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, хэтрэлт хэмнэлт, өр авлагын мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, тайлбар, танилцуулгын хамт холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | 2024 онд яамны аппарат болон харьяа 17 байгууллагын 76 дансны өдөр тутмын 14554 ширхэг 6672,2 тэрбум төгрөгийн өдөр тутмын болоод гадаад, дотоод зарлагын гүйлгээг сар улирлын хуваарийн дагуу хууль журмын хүрээнд хянан баталгаажуулж өр, авлага үүсгэхгүй байх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан. Мөн 2023 оны жилийн эцэс, 2024 оны 1-11 саруудын Сайдын багцын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хуулийн хугацаанд гаргаж хянан баталгаажуулан Сангийн яаманд хүргүүлэн ажиллалаа. | 100 |
| 129. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгоно. | - | Тоо: тухай бүр<br>Чанар: Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хянан, санхүүжилтийг тухай бүр олгосон байна. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцад батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт 2024 оны 12-р сарын 06-ны өдрийн байдлаар 31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 23,357.2 сая төгрөгийг олгосон байна. | |
| 130. | Салбарын өмч хөрөнгийн нэгдсэн бүртгэл тайлан гаргах, түүнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, харьяа байгууллагуудын холбогдох ажилтныг мэргэжил арга зүйгээр хангаж, салбарын өмч хөрөнгийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлнэ. | - | Тоо тухай бүр<br>Чанар: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол, бусад хууль журмын хэрэгжилтийг хангах | | Салбарын өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт сайжирч, шилжилт хөдөлгөөнийг цаг тухайд нь хийж, бүртгэлээр хяналт тавьж ажилласан байна. | Харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй судалгаа авч, нэгтгэн 2025 оны хөрөнгө оруулалтын хувиарлалтад шаардлагатай тоног төхөөрөмжийн тооцоолол судалгаа гаргаж, мэдээллийн сан үүсгэж, шаардлагатай холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллаж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт салбарын өмч хөрөнгө, бүртгэлтэй холбоотой асуудлаар тухай бүр санал хүсэлт хүргүүлэн шийдвэрлүүлэн ажиллах арга хэмжээг авч ажиллаж байна. | 100 |
| 131. | Улсын төсвийн болон гадаад эх үүсвэрээр салбарт хэрэгжүүлсэн шинэ барилга, тоног төхөөрөмжийг тухай бүр бүртгэл тайланд тусгуулна. | - | Тоо: 8<br>Чанар: Шинээр баригдсан барилга болон тоног төхөөрөмжийг холбогдох хууль журмын хүрээнд тухай бүр бүртгэл тайланд бүрэн тусгуулах | | Шинээр баригдсан барилга болон худалдан авсан тоног төхөөрөмжийг тухай бүр бүртгэл тайланд бүрэн тусгуулсан байна. | ГБХНХЯ-ны сайдын 2024 оны А/09, А/134 дүгээр тушаалуудаар Улсын төсвийн болон гадаад эх үүсвэрээр салбарт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний нийт 4,9 тэрбум төгрөгийн шинээр бий болсон барилга, тоног төхөөрөмжийн хуваарийг батлаж харъяа байгууллагуудын тайлан бүртгэлд тусгуулан ажилласан. | 100 |
| 132. | Нэгжийн дотоод аудитын хэрэгжилтийг хангах санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд гарах эрсдэлийг бууруулах, санал дүгнэлт боловсруулна. | | Тоо: Хяналт хэрэгжүүлсэн тайлан, танилцуулга 1<br>Чанар: Төрийн сангийн болон нэгжийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд үүсэх эрсдэлийг бууруулах | | Төрийн сангийн болон нэгжийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлж, эрсдэлийг тодорхойлон, удирдлагад танилцуулсан байна. | Хүүхэд хамгааллын зардалд 2024 онд олгосон зардлын хуваарилалт, зарцуулалтад холбогдох байгууллагуудаас санхүүгийн мэдээллийг ирүүлж, тухайн зардлыг зохих хууль журмын хүрээнд зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулан ажиллаж байна. Мөн "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3,9,8-д заасны дагуу төрийн сангийн нэгжийн эрсдлийн түвшинг үнэлж, эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлийн үнэлгээний тайланг 2024 оны 01 дүгээр сарын 11-нд 03/108 тоот албан бичгээр Сангийн Яаманд хүргүүлсэн байна. | 90 |
| ***Зорилт 3. Гадаадын төсөл, хөтөлбөрийн төсвийн нэгдсэн төлөвлөлтийн зохицуулалтыг хангах, төрийн сантай харилцах*** | | | | | | | |
| 133. | Гадаадын төсөл, хөтөлбөрийн зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний | | Тоо: Төлөвлөлтийн нэгтгэсэн санал, танилцуулга 1<br>Чанар: Төсөл хөтөлбөрийн | | Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн саналыг | Салбарын гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй төслүүдэд тогтмол хяналт тавьж холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг хянан баталгаажуулж санхүүжилт болон бусад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлнэ. | | төлөвлөлтөд холбогдох саналыг нэгтгэн боловсруулж хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэх | | нэгтгэн, тайлбар, танилцуулгын хамт холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | хүсэлтийг боловсруулан Сангийн яаманд уламжилж байна. | |
| 134. | Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хангах, тайлан, мэдээг нэгтгэн боловсруулж удирдлагыг мэдээллээр хангаж ажиллана. | | Тоо<br>Чанар: Төсөл хөтөлбөрийн тайлан, мэдээг цаг тухай бүр нэгтгэн удирдлагыг мэдээллээр хангах | | Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайлан, мэдээг Сайд, ТНБД-д танилцуулж талуудыг уялдаа холбоог хангаж ажилласан байна. | Салбарын гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй төслүүдэд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, зарцуулалт, тайлагналтад хяналт тавьж холбогдох тайлан мэдээг нэгтгэж удирдлагуудыг мэдээллээр хангаж ажиллаж байна. Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд 2024 жилийн эцсийн байдлаар холбогдох хууль журмын дагуу нийт 46,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. | 100 |
| ***Зорилт 4. Салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх, худалдан авалтыг зохион байгуулах, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх, дүн шинжилгээ хийх, мэдээллээр хангах.*** | | | | | | | |
| 135. | Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангаж, мэдээллийн сан бүрдүүлнэ. | | Тоо<br>Чанар: Салбарын худалдан авах ажиллагааны, төлөвлөгөө, тайлан, мэдээг хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх | | Салбарын худалдан авах ажиллагааны, төлөвлөгөө, тайлан, мэдээг хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж, мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөө бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам зааврыг хэрэгжүүлэх талаар харьяа агентлаг, газар хэлтсүүдийг мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллаж байна.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын байгууллагуудын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөлт болон гүйцэтгэлийг цахим систем /Tender.gov.mn/ -ээр хянаж ажиллаж байна. Цахим хуудсанд нийт 37 байгууллага 2023 оны худалдан авах ажиллагааны тайланг илгээн байршуулсан ба 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 42 байгууллага байршуулсныг хянан баталгаажуулж холбогдох заавар зөвлөмжөөр хангаж ажиллаж байна. | 90 |
| 136. | Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй төсөл арга хэмжээ болон эрх шилжсэн төсөл, арга хэмжээний ажлын явцад хяналт тавьж, гүйцэтгэлийг хангуулах, хянан баталгаажуулж, санхүүжүүлэх, | | Тоо<br>Чанар: Эрх шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж мэдээллийн сан бүрдүүлэх | | Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч талуудын ажлын уялдаа холбоог хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй төсөл арга хэмжээ болон эрх шилжсэн төсөл, арга хэмжээний ажлын явцад хяналт тавьж, гүйцэтгэлийг хангуулж, хянан баталгаажуулан ажиллаж байна. Засгийн газрын тогтоолоор эрх шилжсэн төсөл арга хэмжээнээс удаашралтай байгаа дараах арга хэмжээнүүд авч ажиллаа. Тухайлбал:<br>1. Хөвсгөл аймгийн Ахмадын өргөөний байр /Хөвсгөл, Улаан-Уул, Ханх, Эрдэнэбулган, Мөрөн/ төсөл арга хэмжээний магадлалын | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад хяналт тавина. | | | | | дүгнэлт албажаагүй тул арга хэмжээ авч ажиллахыг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01/1013 дугаар албан бичиг<br>2. Говь-алтай аймгийн Есөнбулаг суманд хэрэгжих Ахмадын холбоо, сувиллын барилга төсөл арга хэмжээний төсөвт өртөг аудитын дүгнэлтээр өөрчлөгдсөнтэй холбоотой хэрэгжилт удааширсан тул 2024 оны 01/1033 дугаар албан бичиг,<br>3. Дундговь аймгийн Гурвансайхан сум Ахмадын өргөөний барилга төсөл арга хэмжээний магадлалын дүгнэлт албажаагүй байсан тул 2024 оны 10 дугаар 25-ны өдрийн 01/1012 тоот албан бичгээр тус тус чиглэл хүргүүллээ. | |
| 137. | Тендерт шалгарсан байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах, гэрээний төсөвт өртгийн санхүүжилтийн хуваарь боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулах, талуудын уялдаа холбоог ханган ажиллах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд зохицуулалт хийх, төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлнэ. | | Тоо<br>Чанар: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулан, мэдээллийн сан бүрдүүлэх | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийг холбогдох хууль журмын хүрээнд зохион байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулан мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 2024 онд шинээр болон шилжин хэрэгжиж байгаа 43 төсөл арга хэмжээ байгаагаас шинээр хэрэгжих 30 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалт зохион байгуулахаас эрх шилжин хэрэгжиж байгаа Дундговь аймгийн Гурвансайхан сумын “Ахмадын хөгжлийн төвийн барилга”-ын тендер нь магадлалын дүгнэлт нь төсөвт өртгөөс өндөр гарсан шалтгаанаар зарлагдаагүй, ТХААГ дээр зохион байгуулагдах Баянзүрх дүүрэг дэх “Гэр бүлийн хөгжлийн төвийн барилга”-ын тендер газрын асуудал шийдвэрлэгдээгүй шалтгаанаар зарлагдаагүйгээс бусад төсөл арга хэмжээдийн тендер зарлагдан үр дүн гараад байна. Нийт 24 байгууллага аж ахуйн нэгтжтэй гэрээ байгуулагдан хэрэгжиж байна.<br>Мөн Сангийн Сайдад Гэр бүл , хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас санхүүжүүлж буй нэмэлт хөрөнгө шаардлагатай гэж үзсэн шилжих төсөл, арга хэмжээнүүдийн тоо, төсвийн мэдээлэлийг холбогдох байгууллагуудтай хамтран цуглуулан нэгтгэж холбогдох шийдвэрийг гаргуулах саналыг Сангийн Сайдад хүргүүлсэн. | 90 |
| 138. | Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд ажиллах, тендер шалгаруулалтыг хууль | | Тоо<br>Чанар: Худалдан авах ажиллагааг хууль, журмын хүрээнд зохион байгуулах | | Салбарт хэрэгжих төсөл, арга хэмжээ хугацаандаа бүрэн хэрэгжиж, санхүүжигдсэн байна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан шинээр хэрэгжих 30 арга хэмжээний худалдан авах ажиллагаа явагдахаас Засгийн газрын 2023 оны 409 дугаар тогтоолын дагуу 15 арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг нийслэл, аймгийн засаг даргад, 8 арга хэмжээг Төрийн худалдан авах ажиллагааны газарт эрх шилжүүлэн зохион байгуулахаар | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоомжийн дагуу зохион байгуулна. | | | | | холбогдох материалыг хүргүүлэн ажиллалаа. Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем болон, худалдан авах ажиллагааны цахим системд тус тус шилжүүлэн баталгаажуулан ажиллалаа. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр зохион байгуулагдах 11 арга хэмжээний үнэлгээний хороо байгуулагдан худалдан авах ажиллагаа зохион байгууллагдсанаас 8 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулагдсан бөгөөд 2 төсөл арга хэмжээний /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын байгууллагуудад албан хэрэгцээний компьютер, тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээ, Ахмад настны үндэсний төвийн автобус худалдан авах төсөл арга хэмжээ/ тендер 3 удаа зарлагдаж амжилтгүй болсон, 3 тендер зарлагдаж тендер хүлээн авч байгаа болон үнэлэх шатандаа хэрэгжиж байна. | |
| 139. | Салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, мэдээллийн сан бүрдүүлнэ. | | Тоо<br>Чанар: Салбарт улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж мэдээллийн сан бүрдүүлэх | | Салбарт улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгатай төсөл, арга хэмжээний хэрэгжилт мөн он дамжсан удаашралтай хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний судалгааг гаргаж цаашид эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна. | 90 |
| ***5. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ*** | | | | | | | |
| 140. | ВЭБ-д суурилсан дотоод хяналт, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний системийг нэвтрүүлэх, суурилуулах, ажилтнуудыг нэгдсэн арга зүйгээр хангана. | Улсын төсөв 18.0 сая төгрөг | Сэтгэл ханамжийн үнэлгээний нэгдсэн системийг нэвтрүүлж хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн тоо | Сэтгэл ханамжийн үнэлгээний нэгдсэн систем киоск машиныг 30 газар, хэлтэст суурилуулж байршуулсан байна. | Үнэлгээний системийг хэрхэн ашиглах талаар доод шатны байгууллага, ажилтнуудыг сургасан байна. | Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01/703 тоот албан бичгээр үнэлгээний системийн ашиглалт, хэрэглээ болон орон нутгийн ажилтан, албан хаагчдыг энэ чиглэлийн мэдлэг, мэдээлэлтэй болгож өдөр тутамын үйл ажиллагаандаа тогтмол ашиглах, талаар чиглэл хүргүүлсэн.<br>Чиглэлийн дагуу ХХҮЕГ-с дүүрэг, аймгийн газар, хэлтсүүдэд сэтгэл ханамжийн үнэлгээний системийг ажиллуулах үүрэг чиглэл өгч, санхүүжилтийн хуваарийг баталсан. | 100 |
| 141. | Олон улсын байгууллага, донор байгууллагуудтай | АХБ, ДБ, НҮБ | Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн тоо | АХБ, ДБ, НҮБ | Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, бодлогын хүрээнд | Донор байгууллагуудтай ажлын биелэлт болон ирэх оны ажлын төлөвлөгөөгөө танилцуулсан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | салбарын бодлогын хүрээнд хамтран ажиллана. | | | | хамтран ажилласан байна. | Л.Энх-Амгалан 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Донор байгууллагууд болон төсөл хөтөлбөрүүдтэй уулзалт зохион байгуулж яамны үйл ажиллагаа болон цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөөг танилцуулж ажилласан.<br>Мөн 2024 онд нийт 18 гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдууд болон донор байгууллагуудын Монгол дахь суурин төлөөлөгч нартай уулзалт хийсэн байна. Европын Холбоо, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан. | |
| 142. | Салбарын статистикийн болон танилцуулга, тайлан мэдээг боловсруулах, холбогдох албан хаагчийг мэдээллээр хангана. | үйл ажиллагаан ы зардал | Боловсруулсан илтгэл, танилцуулга, товхимлын тоо | Бэлтгэл ажлын хангаж байгаа | 20 постер, илтгэл, ном товхимол бэлтгэсэн байна. | 38 постер, илтгэл, ном товхимол бэлтгэсэн. | 100 |
| 143. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, таниулан, эмхэтгэл боловсруулж, хэвлүүлнэ. | 40.0 сая төг. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн эмхэтгэл-1 | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн эмхэтгэлийг боловсруулж хэвлүүлсэн. /300ш/ | Төлөвлөгөөнд тусгасны дагуу 1 эмхэтгэл боловсруулан хэвлүүлсэн байна. | Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний заавар”-ыг 650 ширхэгийг хэвлүүлсэн. Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд дагаж гарсан дүрэм журмыг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Нийгмийн даатгалын үйлчилгээний брошур танилцуулгын эхийг бэлтгэж 250 ш хэвлүүлсэн. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлогод хийсэн шинжилгээний дүгнэлт, зөвлөмж эхийг бэлтгэж, 300ш хэвлүүлж, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, гишүүд, болон харьяа агентлагын дарга нарт хүлээлгэн өгсөн. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэхээр баталсан дүрэм, журам, зааврuудыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны https://mflsp.gov.mn/content/detail/3137 цахим хуудсанд байршуулж 14989 удаа аж ахуй нэгж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллага, иргэд хандаж мэдээлэл авсан байна. | |
| 144. | Жижиг, дунд бизнес болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гарын авлага боловсруулан гаргана. | ОУ-ын төсөл хөтөлбөр | Гарын авлагын төслийг боловсруулсан байна. | | Гарын авлагыг боловсруулан, хэвлүүлж түгээсэн байна. | Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэй Малчдад зориулсан гарын авлагыг хэвлүүлэн 21 аймаг 9 дүүрэгт тараасан. Мөн ажил олгогч эздийн байгууллага, ОУ-ын хөдөлмөрийн байгууллагатай хамтран түүхий эд, арьс шир, нэхмэл эдлэл, гутал үйлдвэрлэлийн салбарт баримтлах хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын практик дүрмийг боловсруулан гарын авлаг ном болгон аж ахуйн нэгж, байгууллагад тараасан. Мөн хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан хөдөмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн олон улсын удирдамжийг орчуулан боловсруулж, 2025 онд аж ахуйн нэгж, байгууллагад түгээхээр төлөвлөж байна. | 100 |
| 145. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах, шалгалт авах журам”-ын дагуу үндэсний хэмжээнд ХАБЭА-н сургагч багш нарыг бэлтгэнэ. | ҮОМШӨДС 40.0 сая төгрөг | Сургагч багш нарыг бэлдсэн байна. | Сургагч багш нарын мэдээллийн сан үүссэн байна. | Сургалт зохион байгуулсан байна. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургагч багшийн сургалтыг ХАБЭА-ын сургалтын байгууллагуудын багш нар болон төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагуудын ХАБЭА-н ажилтнууд зэрэг 4 салбарын нийт 240 ажилтанд зохион байгуулахаар “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөө”-нд тусган саналаа хүргүүлсэн боловч тус зардал батлагдаагүй удсан тул сургагч болох хүсэлт тавьсан аж ахуйн нэгж байгууллагын өөрсдийн төсвөөр 2024 онд 45 сургагч багшийг бэлдсэнээр нийт 247 сургагч багш бэлтгэгдээд байна. | 100 |
| 146. | Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийгмийн халамжийн салбарын ажилтнуудын чадавхи бэхжүүлэх, мэргэжил аргазүйгээр хангах ажлыг зохион байгуулна.<br><br>*/ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 3.9/* | 90.0 сая төгрөг | Сургалт-2 | 2023 онд сургалт хийгдээгүй. Салбарын ажилтнуудын чадавх бэхжүүлэх ажил зохион байгуулагдаагүй. | Сургалт зохион байгуулсанаар Нийгмийн халамжийн хууль, тогтоомжийн шинэчлэл, цахим үйлчилгээтэй холбоотой асуудлаар салбарын ажилтан албан хаагчдын мэдлэг ур чадвар дээшилж, иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд гардаг хүндрэл, | Дэлхийн банкны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд “Гөү Смарт” ХХК-тай гэрээ байгуулан хүний нөөцийг тасралтгүй сургах онлайн сургалтын платформыг худалдан авч Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2022 оны 10 дугаар сард хүлээлгэн өгсөн.<br>Энэхүү платформыг ашиглан сургалтын агуулгыг тухайн байгууллагууд өөрсдийн онцлогт нийцүүлэн баяжуулж, нэмэгдүүлж, шинэчлэх боломжтой тул сургалт хариуцсан нэгжид хариуцуулж ашиглалтыг эрчимжүүлэх талаар 2022, 2024 онуудад чиглэл хүргүүлж ажилласан. Уг чиглэлийг биелэлтийг ХХҮЕГ-ын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чирэгдлийг буурууулсан байна. | 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 01/1582 дугаар албан бичгээр яаманд ирүүлсэн.<br>Яамнаас өгсөн чиглэлийн дагуу:<br>• Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн байгууллагын албан хаагчдын судалгааг авч, нийт 1491 албан хаагчийг платформд бүртгэсэн.<br>• Дэлхийн Банкны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Нийгмийн халамжийн салбарын ажилтнуудыг тасралтгүй сургах хүний нөөцийн онлайн модуль боловсруулах ажлыг Улаанбаатар ньюс ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд тус байгууллагаас боловсруулсан 6 үндсэн багц сэдвийн /1.Нийгмийн халамжийн түүх, бодлого хэрэгжилт, 2. Хувь хүний хөгжил стресс менежмент, 3.Нийгмийн ажлын удирдлага, 4.Үр дүнтэй нийгмийн халамжийн тогтолцоо, Нийгмийн халамжийн цахим шилжилт, 5. Ядуу өрх, иргэнтэй ажиллах төгсөлтийн аргачлал, 6.Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох орлогыг орлуулан тооцох шинэ аргачлал/ онлайн сургалтын контент, гарын авлага, материалуудыг боловсруулж, сургалтын платформд байршуулсан.<br>• 2024 онд Нийслэлийн халамжийн үйлчилгээний газартай хамтран салбарын шинэ ажилтныг чадавхжуулах 3 модуль сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст шинээр томилогдсон албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан.<br>• Сургалтын платформд Удирдлагын академийн багш Т.Жаргал, Т.Төмөр нарын “Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах нь”, “Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэх” сэдэвт сургалтын хичээл, Төрийн албаны зөвлөлийн “Төрийн албан хаагчийн ёс зүй, бодлого, үйл ажиллагаа”, ҮСХ-ны салбарын албан хаагчдад зориулсан Stata программын сэдэвт сургалтын хичээлүүдийг байршуулсан.<br>• Нийгмийн халамжийн үйлчилгээний цахимжуулалтын хүрээнд Халамжийн нэгдсэн систем хэрэглэгчдийн систем ашиглах мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 1 гарын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авлага, 12 видео хичээлийг боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>• Халамжийн нэгдсэн системд орон нутгийн төсөвтэй үйлчилгээнүүдийн гүйлгээг төрийн сан руу илгээх талаар 21 аймаг, 9 дүүргийн 31 халамжийн сангийн ахлах мэргэжилтнүүдэд цахимаар сургалт зохион байгуулж арга зүйгээр хангаж ажиллалаа.<br>• Азийн хөгжлийн банкны зөвлөхүүдийн гүйцэтгэсэн халамжийн тайлангийн системийг хэрхэн ашиглах, тайлан гаргах, халамжийн нэгдсэн системтэй тулгах талаар 21 аймаг, 9 дүүргийн Олголт хариуцсан мэргэжилтнүүдэд цахимаар сургалт байгуулж сургалтад нийт 31 албан хаагч хамрагдсан.<br>• Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороо, мэдээллийн технологийн төвийн зөвлөхүүдтэй хамтран 2024 оны 04 сарын 02-ны өдөр аймаг, дүүргүүдийн статистик тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг цахимаар зохион байгуулж сургалтанд нийт 65 мэргэжилтнүүд хамрагдсан болно. Сургалтын гарын авлага, мэдээ тайлангийн маягтуудыг сургалтын платформ ашиглан гарын авлага болгон байршуулсан.<br>-Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөрт хамрагдсан өрхтэй ажиллаж байгаа хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд СХД, ЧД, БЗД-ийн 45 хорооны Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан дараах сургалт, арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд: Төгсөлтийн аргачлалын Модуль 3 “Нийгмийн хамгаалал” Модуль 4 “Санхүүгийн оролцоо” сургалтыг зохион байгуулсан бөгөөд уг сургалтын үр дүнд төгсөлтийн аргачлалын үндсэн тулгуур багана болох “Нийгмийн хамгаалал”, “Санхүүгийн оролцоо”-ны талаарх мэдлэг, ойлголттой болохоос гадна асуудлын хүрээнд зорилтот өрхтэй ажиллах чадавхид суралцаж, арга хэмжээг хэрэгжүүлэх, өрх төгсөх шалгуурын талаар мэдээлэлтэй болсон байна. Мөн өрхийг бүлэг болгон нийгэмшүүлэх, бүлгээр дамжуулан өрхийн дасгалжуулалтыг болон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өрхийн санхүүгийн боловсролыг хэрхэн олгох ур чадварыг нэмэгдүүллээ.<br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Төрөлжсөн асрамжийн үйчилгээний цахим систем”-ийг хөгжүүлэн 2024 оны 04 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд улсын болон орон нутгийн өмчийн 12 асрамжийн газрын 37 ажилтан, албан хаагчид систем ашиглалт, нэвтрүүлэлтийн чиглэлээр сургалт зохион байгуулж ажиллалаа. Энэхүү систем нэвтэрснээр иргэн асрамжийн газарт асруулах хүсэлтээ цахимаар гаргах боломж бүрдэхээс гадна, төрөлжсөн асрамжийн байгууллагуудын танилцуулга, статистик тоо, төсөв, санхүүгийн мэдээллийг багтаасан томоохон мэдээллийн сан бүрдэх юм.<br>-Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний //www.asramj.ehalamj.mn// цахим системийг шинээр хөгжүүлж, ашиглалтад оруулахтай холбогдуулан улс, орон нутаг, хувийн хэвшлийн асрамжийн газрын нийт 40 орчим ажилтнуудыг хамруулсан сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж, ном гарын авлагаар хангаж, сертификат олгосон.<br>-Монголын улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран Нийслэлийн хэмжээнд 60 сайн дурын идэвхтнийг гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэхэд, мөн 35 нийгмийн ажилтныг анхны тусламжийн үйлчилгээг үзүүлэхэд сургаж, дадлагажуулах сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгууллаа. Эдгээр сайн дурын идэвхтнээр дамжуулан хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийнхэнд чиглэсэн зөвлөгөө өгөх, нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, түр байрлуулан асрамжлах үйлчилгээг төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн байна. | |
| 147. | Хөдөлмөрийн хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах төлөвлөгөө гарган ажиллана. | Олон улсын байгууллагын санхүүжилт | Төлөвлөгөө-1; Сургалт; | Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимүүлэх ажлын төлөвлөгөөг ХНХ-ын сайдын 2023 оны А/124 дүгээр тушаалаар | Хөдөлмөрийн хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах төлөвлөгөө батлуулж, сургалтууд зохион байгуулсан байна. | “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарах асуудал, цаашдын зорилго” Соёлын өвийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо зэрэг 5-6 байгууллагад мэдээлэл хийж хуулийг олон нийтэд таниулах үйл ажиллагааг зохион байгуулж байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | батлан хэрэгжилтийг хангаж ажилласан. | | | |
| 148. | Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны гишүүдийг чадавхижуулах сургалтыг хийнэ. | Олон улсын байгууллагын санхүүжилт | Сургалт | Зарим аймагт сургалтыг зохион байгуулсан | Орон нутагт сургалт зохион байгуулсан байна. | МҮЭХ, НҮБХХ-ийн төсөлтэй хамтран 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөрийн маргаан зохицуулах хороонд Ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үүрэг хүлээсэн байгууллагыг төлөөлөн ажилладаг гишүүдэд Хөдөлмөрийн маргаан зохицуулалтын асуудлаар мэдээлэл хийн сургалт зохион байгуулсан. | 100 |
| 149. | Хөдөлмөрийн маргаан зохицуулалтын асуудлаар, маргалдагч талуудыг эвлэрүүлэх, харилцан тохиролцох байдлыг үүсгэхэд шаардлагатай гарын авлага, аргачлалыг боловсруулж түгээнэ. | Олон улсын байгууллагын санхүүжилт | Гарын авлагын төсөл | “Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм”, “Хөдөлмөрийн арбитрын дүрэм”, “Хөдөлмөрийн сонирхлын маргааныг хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр зохицуулах журам”, “Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны дүрэм”-ийн хэрэгжилт | Хөдөлмөрийн маргаанд маргалдагч талуудыг харилцан тохиролцох байдлыг үүсгэхэд шаардлагатай гарын авлага боловсруулсан байна. | Олон улсын хөдөлмөрийн байгууллагын олон улсын сургалтын төв (ОУСТ)-өөс зохион байгуулж байгаа “Хөдөлмөрийн маргааныг эвлэрүүлэн зуучлах” сургалтын цахим платформд бүртгэл үүсгэн эхний үе шатыг 2024 оны 06 дугаар сарын 03-16-ны хооронд зохион байгуулав.<br>Танхимын сургалтыг 06 дугаар сарын 17-21-ний хооронд Улаанбаатар хотод зохион байгуулж байгаа бөгөөд энэхүү сургалтад Хөдөлмөрийн зуучлагч, хөдөлмөрийн арбитрч, Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны төлөөлөл, эрдэмтэн, судлаач, мэргэжилтнүүдээс бүрдсэн нийт 24 оролцогч хамрагдсан.<br>Олон улсын хөдөлмөрийн байгууллагын олон улсын сургалтын төв (ОУСТ)-өөс 4 мэргэжилтэн Монгол улсад ирж хичээлийг заасан.<br>- Хөдөлмөрийн маргаанаас урьдчилан сэргийлэх, маргааныг зохицуулах<br>- Монгол Улсын хөдөлмөрийн маргаан зохицуулах тогтолцооны үнэлгээ<br>- Монгол Улсын хөдөлмөрийн маргаан зохицуулах тогтолцооны үнэлгээ<br>- Эвлэрүүлэх/зуучлах ажиллагаа<br>- Хөдөлмөрийн маргаанаас урьдчилан сэргийлэх зэрэг 5 модуль хичээлийг тус бүр даалгаврын хамтаар орсон. Энэхүү сургалтад хамрагдсан 24 хүнд сертификат олгосон. | 90 |
| 150. | Жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдад зориулсан Хөдөлмөрийн тухай хуулийн хялбаршуулсан гарын | үйл ажиллагааны зардал | Гарын авлага | Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэглээ, арга зүйн талаар гарын авлага гараагүй. | Гарын авлагыг боловсруулж, хэвлүүлэн харьяа газар, хэлтсээр түгээсэн байна. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын тушаалаар гарын авлага боловсруулах ажлын хэсэг, шаардагдах төсвийг баталсан. Ажлын хэсгийг УИХ-ын даргын ахлах зөвлөх Ц.Мөнх-Оргил ахалж ажиллаж байна. Ажлын хэсгээс гарын авлагын агуулгыг 12 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авлага боловсруулж гаргана. | | | | | бүлэгт хуваан гарын авлагын төслийг боловсруулан ажиллаж байна. | |
| 151. | Нийгмийн ажил үйлчилгээний нийтлэг шаардлага стандарт MNS 6949:2021 –ын хэрэгжилтийг хангуулна. | Улсын төсөв | Сургалт-1 | Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтад хамтарсан багийн нийгмийн ажилтныг чадавхижуулах, кэйс дээр ажиллах сургалт хийсэн. | Хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтныг чадавхжуулах сургалтыг 21 аймаг, нийслэл, дүүрэг, асрамж, халамж, анхан шатны нийгмийн ажилтнуудад зорилтот бүлэгт суурилсан кэйс менежментийн аргаар төрөлжүүлэн хийнэ. | Нийгмийн ажил үйлчилгээний нийтлэг шаардлага стандарт MNS 6949:2021 –ын хэрэгжилтийг хангуулах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гамшгийн үед гэр бүл, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамтарсан баг болон малчин өрхийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг Дэлхийн зөн Олон Улсын байгууллагатай хамтран Төв аймгийн Баянчандмань суманд 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан. Хамтарсан багийн гишүүд, нийгмийн ажилтны үүрэг, оролцоо болон хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга зүй, хүчирхийлэлд хариу арга хэмжээ авах нь сэдвийн хүрээнд сургалтын хөтөлбөр, модулийг хамтран боловсруулсан. Туршилтын сургалтын дараа Архангай, Баян-Өлгий, Дорноговь, Увс, Ховд аймгуудын 189 хамтарсан багийн гишүүдийг сургалтад хамруулсан. Архангай аймагт явагдсан сургалтад Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын Сургалт, судалгаа мэдээллийн төвийн мэргэжилтэн Б.Амарзаяа оролцсон.<br>Сургалтын ерөнхий зохион байгуулалт:<br>•Сургалтад төлөвлөсөн ёсоор Зудын яаралтай хариу арга хэмжээ 2 төслийн хүрээнд өвс, тэжээлийн тусламж авсан сумдын хамтарсан багийн гишүүдийг хамруулсан.<br>•Сургалтыг модулийн дагуу 8 цагийн агуулгатай сургалтыг зохион байгуулсан.<br>•Сургалтын ерөнхий зохион байгуулалтыг Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Хөрөнгө бүрдүүлэлтийн мэргэжилтэн Э.Мөнх-Эрдэнэ хариуцан ажилласан бол орон нутгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын удирдлага, нийгмийн ажилтнууд орон нутгийн зохион байгуулалтыг хийсэн. | 100 |
| 152. | Нийгмийн ажлын кейс менежмент хийх олон улсын аргачлалыг нэвтрүүлэхэд чиглэсэн гарын авлагыг орчуулж, хэвлүүлэн түгээх, улсын | Олон улсын төсөл, хөтөлбөр 20.0 сая төгрөг | Гарын авлага-1<br>Сургалт -1 | Олон улсад хэрэглэгддэг гарын авлага боловсруулагдсан. | Нийгмийн ажлын кейс менежмент хийх олон улсын аргачлалыг орчуулж, түгээсэн байна. | Хүүхэд хамгааллын тухай хууль 2024 оны 09 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ хуулинд 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн сум, хороонд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтныг ажиллуулж эхлэх тогтолцооны шинэчлэлийг анх удаа хуульчилсан. Хүүхэд хамгааллын кэйс | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээнд цахим сургалт зохион байгуулна. | | | | | менежментийг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх, анх удаа ажиллаж эхлэх 927 хүүхэд хамгааллын нийгмийн ажилтныг сургаж, чадавхжуулах, кэйс менежментийг бодитоор хэрэгжүүлэх туршлага, чадавх манай улсын төрийн байгууллагын анхан, дунд шатанд сул хөгжсөн тул ажилтан, албан хаагчдыг ур чадварыг хөгжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг анхан шатанд хүргэх, мэргэжлийн удирдлагаар хангах хэрэгцээ тулгарсан. Энэ хэрэгцээнд тулгуурлан шинээр ажиллаж эхлэх хүүхэд хамгааллын нийгмийн ажилтанд кэйс менежментийн онол, практик ур чадвар, сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх болон хүүүхэд, гэр бүлийн талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор сургалтын модуль, гарын авлага боловсруулах ажлын даалгаврыг 2024 оны 05 дугаар сард боловсруулж, Олон улсын туршлагыг хамтран хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх хүсэлтийг Дэлхийн Банк-д тавьсан. Энэ ажлын даалгаврыг Дэлхийн банк хүлээн авч, 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрөөс эхлэн уг төслийг хэрэгжүүлэх боломжтой зөвлөх үйлчилгээг зарлаж, Нийгмийн ажлын багш, сургагчдын холбоо ТББ, Отгонтэнгэр, МУИС, АШИУС-ийн нийт 6 зөвлөх болон Дэлхийн Банкны ОУ-ын Зөвлөх нар хамтран Хүүхэд хамгааллын кэйс менежмент, нийгмийн ажлын удирдлага сэдвийн хүрээнд сургалтын модуль, сургагч багшийн гарын авлага болон суралцагчийн гарын авлагыг боловсруулсан. Энэ хугацаанд Олон Улсын байгууллага, анхан шатанд ажиллаж буй боловсрол, шүүх, эрүүл мэнд, халамж, хөгжлийн нийгмийн ажилтнууд, Их дээд сургуулийн багш, судлаачид, мэргэжлийн холбоод оролцсон 3 удаагийн танхимын, 5 удаагийн цахим хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд Сургагч багшийн гарын авлага, суралцагчийн гарын авлагын, сургалтын хөтөлбөр, модулийг хэвлүүлэхэд бэлэн болгосон. Уг сургалтын хөтөлбөр, модулийг батлуулснаар сум, хороонд ажиллаж эхлэх хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны хүүхэд хамгааллын кэйс менежментийг хэрэгжүүлэх онол, практикийн ур чадварыг эзэмших бөгөөд цаашид ажилтан, албан хаагчдын сургалтын хэрэгцээг хангах зорилгоор цахимжуулах шаардлагатай. Гэр бүл, хөдөлмөр, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийгмийн хамгааллын яам энэ зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхэд төлбөр, тооцооны ямар нэг асуудалд оролцоогүй, Дэлхийн Банк-ны дотоодын дүрэм журмаар шийдвэрлэгдэж хийгдсэн болно. | |
| 153. | Албан хаагчдын мэргэжил, мэргэшил, хандлага, зан үйл, ур чадварыг хөгжүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлон яамны хүний нөөцийг чадавхижуулах 2024 оны сургалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлнэ.<br><br>*/ХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө 4.1./* | үйл ажиллагаан ы зардал | Яамны хүний нөөцийг чадавхижуулах 2024 оны сургалтын төлөвлөгөө | Жил бүр | Хүний нөөцийг чадавхижуулах сургалтын төлөвлөгөөг батлан, яамны нийт албан хаагчдын 40-с доошгүй хувийг гадаадын болон дотоодын цахим сургалт семинар, хурал зөвлөгөөн, танилцах аялалд хамруулсан байна. | Албан хаагчдын мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хангахын тулд сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгаа авч, албан хаагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтуудыг оновчтой зохион байгуулах ажлыг төлөвлөн ажиллаж байна. ХНХЯ-ны 2024 оны “Сургалтын төлөвлөгөө”-г боловсруулан батлуулсан бөгөөд албан хаагчдыг шатлан дэвшиж ажиллахад шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд Удирдлагын академийн Төрийн албаны сургуульд албан хаагчийг ахлах болон эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад байгууллагын зардлаар болон улсын төсвийн санхүүжилтээр хамруулах хүсэлт хүргүүлсэнээс эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 6 албан хаагч, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 15 албан хаагч, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагчийг хамруулан суралцуулахаар гэрээ байгуулан ажиллалаа. Мөн цаг үеийн шаардлагад нийцсэн мэдлэг, мэдээллийг олгох үүднээс албан хаагчдыг богино хугацааны зорилтот сургалтад хамруулах ажлыг Төрийн албаны зөвлөл болон Удирдлагын академитай хамтран зохион байгуулж ажиллаж байна. Тайлант хугацаанд яамны 49 албан хаагч эрхэлсэн чиг үүргийн хүрээнд гадаад улсад зохион байгуулагдаж буй сургалтад хамрагдаж, гадаад улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд сургалт, хөтөлбөрт хамруулахаар холбогдох байгууллагуудад албан хаагчдын нэрийг дэвшүүлж шаардлагатай материалыг хүргүүлж ажиллалаа. | 90 |
| 154. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын шагналын болзол, шалгуур хангасан | үйл ажиллагаан ы зардал | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын | Тэмдэглэлт өдрүүдээр ХНХ-ын сайдын | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын шагналын болзол, шалгуур хангасан | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/258 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын шагналын журам”-ыг үндэслэн эрхэлсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | материалыг удирдлагуудад танилцуулан шийдвэрлэнэ. | | шагналын шаардлага хангасан материал | тушаалаар шийдвэрлэдэг. | материалыг удирдлагуудад танилцуулан шийдвэрлэсэн байна. | ажилдаа олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүсийг ГБХНХ-ын Сайдын тушаалаар шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулан ажиллалаа.<br>2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар ХНХ-ын Сайдын А/02, ГБХНХ-ын Сайдын А/03, А/13 тоот тушаалаар Засгийн газрын шагнал "Хөдөлмөрийн тэргүүний ажилтан" тэмдгээр 1473, "Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан" тэмдгээр 545, "Хүндэт жуух" бичгээр 1030 хүнийг шагнасан | |
| 155. | Хяналтын улсын (ахлах) байцаагчдыг чадавхижуулах сургалт зохион байгуулна. | ОУХБ (ILO) 45,0 сая төгрөг | Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөх, зохион байгуулахад анхаарах асуудлаар мэргэшил арга зүйгээр хангах, хяналт шалгалтын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх | Агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн 100 улсын (ахлах) байцаагчид хамрагдана. | Гүйцэтгэл 100 % | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/153 дугаар Сургалт зохион байгуулах тухай тушаалын дагуу 2024 оны 11 дүгээр сарын 25-аас 11 дүгээр сарын 26-ны өдрүүдэд ГБХНХЯ, ХХҮЕГ, НДЕГ, тэдгээрийн харьяа аймаг, дүүргийн хөдөлмөрийн хяналтын 71, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын 16, нийгмийн хамгааллын хяналтын 28, нийт 115 улсын байцаагчдыг хамруулан 2 өдрийн сургалт зохион байгуулсан. Сургалтын санхүүжилтийг Европын Холбооны Улсын дэмжлэгтэйгээр Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын хэрэгжүүлж буй "Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслөөс санхүүжүүлсэн. Сургалтад хамрагдсан улсын байцаагчид Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх шинэ сургалтын 17 модуль хөтөлбөрийн тухай ойлголттой болж, шинэ модуль хөтөлбөрүүдтэй танилцан, хөдөлмөрийн хяналтын талаарх Олон Улсын болон Үндэсний эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн хяналтын бодлого, төлөвлөлтийн талаарх мэдлэгтэй болж, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эмзэг бүлгийн ажилтнуудын нөхцөл байдлыг харгалзан хөдөлмөрийн хяналтын үзлэг шалгалт хийх, ажлын үр дүнг дээшлүүлэх арга хэрэгсэл, чадавхиа нэмэгдүүлсэн. | 100 |
| | | | | | | | **95.0** |

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД ......................... /Л.ЭНХ-АМГАЛАН/

*Тэмдэг* ............................

*(огноо)*

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ......................... /Л.МӨНХЗУЛ/

*Тэмдэг* ............................

*(огноо)*